



ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ ᠶᠡᠳᠡᠪᠬᠡ

ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА **4**

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН



ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. ХЯНАСАН

Авирмэдийн Амарбал

Эдийн засагч-Хүн ам зүйч, Хүн ам зүйн ухааны доктор

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга, Хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын нарийн бичгийн дарга

Төмөрбаатарын Болор-Эрдэнэ

Эдийн засагч-Хүн ам зүйч

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Гүржавын Энх-Амгалан

Эдийн засагч, статистикч, Бизнесийн удирдлагын магистр

Цэрэндаваагийн Гэрэлтуяа

Бизнесийн удирдлага

ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Энхтайваны Гантуяа

Статистикч, Эдийн засгийн ухааны магистр

Ичинноровын Цэрэндулам

Эдийн засагч-Статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр

<http://www.nso.mn>

И-мэйл: information@nso.mn Утас: 11-321433



АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ЕРӨНХИЙ ТОЙМ.....	7
МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМ	12
ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ	14
ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ	14
ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ	15
ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО.....	18
АЖИЛЛАХ ХҮЧ.....	20
АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН	21
АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ.....	35
АЖИЛЛАГЧИД.....	40
АЖИЛЛАГЧИД, ТЭДГЭЭРИЙН БҮТЭЦ.....	41
АЖИЛЛАГЧИД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	47
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН	55
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ДЭХ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ	58
АЖИЛГҮЙДЭЛ	61
АЖИЛГҮЙ ИРГЭД, ТЭДГЭЭРИЙН БҮТЭЦ.....	62
АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН.....	66
ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЭЛ.....	68
БҮС, ОРОН НУТГИЙН ЯЛГАА	72
ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН БҮТЦИЙН ЯЛГАА.....	73
АЖИЛЛАГЧДЫН ЯЛГААТАЙ БАЙДАЛ.....	79
АЖИЛГҮЙДЛИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ.....	81
ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД.....	83
ХАВСРАЛТ.....	87
1. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	88
2. НЭМЭЛТ ХҮСНЭГТҮҮД	100



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Суурин хүн ам, хүн амын нягтрал, аймгаар, 2010, 2020 он.....	13
Хүснэгт 1.2. Суурин хүн ам, насны бүлэг, хүйсээр, хүйсийн харьцаагаар, 2020 он.....	14
Хүснэгт 2.1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал.....	19
Хүснэгт 2.2 Ажиллах хүч, насны бүлэг, хүйс, байршлаар, 2020 он.....	21
Хүснэгт 2.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, 2010, 2020 он.....	22
Хүснэгт 2.4. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2010, 2020 он...	23
Хүснэгт 2.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, хот, хөдөөгөөр, 2010, 2020 он.....	24
Хүснэгт 2.6. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, байршлаар.....	25
Хүснэгт 2.7. Ажиллах хүчний оролцооны түвшин, байршил, хүйс, боловсролын түвшин..	27
Хүснэгт 2.8. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, шилжих хөдөлгөөний байдлаар.	32
Хүснэгт 2.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцоо, 2020 он.....	34
Хүснэгт 2.10. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, шалтгаанаар, 2010, 2020 он.....	35
Хүснэгт 2.11. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, насны бүлэг, байршлаар, хүйсээр.....	37
Хүснэгт 2.12. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, байршил, насны бүлгээр, 2020 он.....	38
Хүснэгт 2.13. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, шалтгаан, боловсролын түвшнээр.....	39
Хүснэгт 3.1. Ажиллагчид, хот, хөдөө хүйсээр, 2010, 2020 он.....	41
Хүснэгт 3.2. Ажиллагчид, насны бүлэг, хүйсээр, мянган хүнээр, 2010, 2020 он.....	42
Хүснэгт 3.3. Ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар.....	44
Хүснэгт 3.4. Ажиллагчид, гэрлэлтийн байдлаар, хүйсээр, 2010, 2020 он.....	45
Хүснэгт 3.5. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насны бүлгээр.....	47
Хүснэгт 3.6. Ажиллагчид, хүйсээр, салбараарх дүнд эзлэх хувиар, 2020 он.....	48
Хүснэгт 3.7. Ажиллагчид, салбар, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2020 он.....	49
Хүснэгт 3.8. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байршлаар, 2020 он..	50
Хүснэгт 3.9. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, хувиар, 2020 он.....	52
Хүснэгт 3.10. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, хүйсээр, дүнд эзлэх хувиар....	53
Хүснэгт 3.11. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, хүйс, байршлаар, 2020 он.....	54
Хүснэгт 4.1. Ажилгүй хүн, байршил, бүс, хүйсээр, 2010, 2020 он.....	62
Хүснэгт 4.2. Ажилгүй хүн, насны бүлэг, хүйсээрх дүн эзлэх хувиар, 2010, 2020 он.....	63
Хүснэгт 4.3. Ажилгүй хүн, боловсролын түвшин, хүйсээрх дүнд эзлэх хувиар.....	64
Хүснэгт 4.4. Ажилгүйдлийн түвшин, байршлаар, бүсээр, хүйсээр, 2010, 2020 он.....	66
Хүснэгт 4.5. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр, 2010, 2020 он.....	67
Хүснэгт 4.6. Залуучуудын болон нийт ажилгүйдлийн түвшний харьцаа, 2010, 2020 он.....	69
Хүснэгт 5.1. Ажиллах хүч, бүс, аймаг, хүйсээр, 2010, 2020 он.....	73
Хүснэгт 5.2. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, аймаг, нийслэлээр.....	77
Хүснэгт 5.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, байршлаар, аймаг, нийслэлээр..	77
Хүснэгт 5.4. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшин, аймаг нийслэлээр.....	79
Хүснэгт 6.1. Гадаадад оршин суугаа Монгол Улсын хөдөлмөрийн насны иргэд, насны бүлэг, хүйсээр, 2010, 2020 он.....	84
Хүснэгт 6.2. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, хөдөлмөрийн хэлбэр, хүйсээр....	84
Хүснэгт 6.3. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, насны бүлгээр, хүйсээр.....	85



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Монгол Улсын суурин хүн ам, мянган хүнээр, 2010, 2020 он.....	12
Зураг 1.2. Хүн ам зүйн ачаалал*, 2010, 2020 он.....	15
Зураг 1.3. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо	16
Зураг 1.4. Суурин хүн ам, ажиллах хүчний нас хүйсийн суварга, 2010, 2020 он.....	16
Зураг 2.1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаарх бүдүүвч, 2020 он	20
Зураг 2.2. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хувиар, 2010, 2020 он.....	22
Зураг 2.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2020 он	23
Зураг 2.4. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, байршлаар, 2020 он	25
Зураг 2.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр, 2020 он.....	26
Зураг 2.6. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, боловсролын түвшнээр.....	28
Зураг 2.7. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, боловсролын түвшнээр, 2020 он.....	29
Зураг 2.8. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, боловсролын түвшнээр, 2020 он.....	29
Зураг 2.9. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, гэрлэлтийн байдлаар, 2020 он	30
Зураг 2.10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, сүүлийн 1 жилийн шилжих хөдөлгөөний байдлаар, 2010, 2020 он	32
Зураг 2.11. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөний байдлаар, 2010, 2020 он.....	33
Зураг 2.12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцооны түвшин, бэрхшээлийн хэлбэр, байршлаар, 2020 он	35
Зураг 2.13. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, шалтгаан, дүнд эзлэх хувиар	36
Зураг 2.14. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, шалтгаан, хүйс, дүнд эзлэх хувиар	37
Зураг 3.1. Ажиллагчид, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2020 он	42
Зураг 3.2. Ажиллагчид, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2020 он.....	43
Зураг 3.3. Ажиллагчид, боловсролын түвшин, хүйс, хувиар.....	44
Зураг 3.4. Хөдөлмөр эрхэл буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүйсээр, 2010, 2020 он...	46
Зураг 3.5. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2020 он	46
Зураг 3.6. Дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчид, дүнд эзлэх хувиар, 2020 он	47
Зураг 3.7. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар	48
Зураг 3.8. Ажиллагчид, насны бүлэг, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар	51
Зураг 3.9. Хөдөлмөр эрхлэлтийн хуучин болон шинэ статусын харьцуулалт	53
Зураг 3.10. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршил, хүйсээр	55
Зураг 3.11. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин хүйс, насны бүлгээр	56
Зураг 3.12. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, насны бүлэг, байршлаар	56
Зураг 3.13. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, боловсролын түвшнээр.....	57
Зураг 3.14. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, гэрлэлтийн байдлаар.....	57
Зураг 3.15. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, шилжих хөдөлгөөний байдлаар, 2020 он.....	58
Зураг 3.16. Хөдөө аж ахуйн бус салбарт ажиллагчдад байнгын цалин хөлстэй ажиллагчдын эзлэх хувь, хүйс, байршлаар, 2020 он	59



Зураг 3.17. Ажил мэргэжлийн ялгарал, хүйсээр, 2020 он	59
Зураг 4.1. Ажилгүй хүн, хүйс, насны бүлэг дэх дүнд эзлэх хувиар, 2020 он.....	63
Зураг 4.2. Ажилгүй хүн, хүйс, боловсролын түвшин дэх дүнд эзлэх хувиар, 2020 он	64
Зураг 4.3. Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүй хүн, хүйс, байршлаар, 2020 он.....	65
Зураг 4.4. Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүй хүн,.....	65
Зураг 4.5. Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүй хүн, хүйс, насны бүлгээр, 2020 он.....	66
Зураг 4.6. Ажилгүйдлийн түвшин, гэрлэлтийн байдлаар, 2020 он	67
Зураг 4.7. Ажилгүйдлийн түвшин, шилжих хөдөлгөөний байдлаар, 2020 он	68
Зураг 4.8. Нийт болон залуучуудын ажилгүйдлийн түвшний харьцаа, 2020 он.....	69
Зураг 4.9. 15-24 насны хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын эзлэх хувь, хүйсээр, 2020 он	70
Зураг 5.1. Хөдөлмөрийн зарим үзүүлэлтийн өсөлт, бууралт 2010 онтой харьцуулахад, аймаг, нийслэлээр, пунктээр, 2020 он.....	75
Зураг 5.2. Ажиллах хүчний оролцооны, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр, 2020 он.....	76
Зураг 5.3. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны дэд салбар, аймаг, нийслэлээр	80
Зураг 5.4. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, аймаг, нийслэлээр, 2020 он...	81
Зураг 5.5. Ажилгүй хүн болон ажилгүйдлийн түвшин, аймгаар, 2020 он	82
Зураг 6.1. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэд, зорчсон хугацаагаар, хүйсээр, 2020 он	85
Зураг 6.2. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэд, хөдөлмөрийн хэлбэр, зорчсон хугацаа, хүйсээр, 2020 он.....	86



ӨМНӨХ ҮГ

Улс орны эдийн засгийн бодлогын хамгийн том зорилтуудын нэг нь хөдөлмөр эрхлэлт юм. Хөдөлмөр эрхлэлтийн статистик тоо мэдээллийг шинжилж, түүнийхээ үндсэн дээр үр нөлөөтэй бодлого явуулах нь орчин үеийн эдийн засгийн ухааны чухал асуудал болжээ.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын үр дүнгээр засаг захиргааны бүх түвшинд 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог зүйн хүн ам зүйн болон боловсрол, гэрлэлт, шилжих хөдөлгөөний байдлаар нарийвчлан судлах, ажиллагчдыг эрхэлдэг ажил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) болон бусад үзүүлэлтээр, ажилгүй хүн, ажиллах хүчнээс гадуурх хүн амыг бүтэц, шалтгаанаар нь судлах боломжтой юм. Засаг захиргааны бүх шатанд хөдөлмөр эрхлэлтийн тоо мэдээлэл бий болсноор нийгэм, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Тооллогын үр дүнгээр олон төрлийн эмхэтгэл, тусгайлсан сэдвээр товхимлуудыг нийтэлж байгаагийн нэг болох “Хүн амын хөдөлмөр эрхлэлт” гэсэн энэхүү товхимлыг Та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Хөдөлмөрийн статистикийг нийгэм, эдийн засгийн бусад хүчин зүйлтэй уялдуулан судалж, нарийвчлан үнэлэх болон гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээ хийхэд энэхүү сэдэвчилсэн судалгааны мэдээлэл нь бүх шатны хэрэглэгчдэд чухал мэдээллийн эх үүсвэр болно гэдэгт найдаж байна.



ЕРӨНХИЙ ТОЙМ



ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ

2020 оны байдлаар Монгол Улсын суурийн хүн амын 2.2 сая (67.9%) нь хөдөлмөрийн буюу 15, түүнээс дээш насны хүн ам байгаа нь 2010 оноос 264.6 мянган хүнээр нэмэгдсэн байна. Хэдийгээр хөдөлмөрийн насны хүн ам өссөн ч тэдгээрийн нийт хүн амд эзлэх хувийн жин 4.1 пунктээр буурсан бөгөөд үүнд 0-14 насны болон 65, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн жин 2010 оноос өссөн нь нөлөөлжээ.

Мөн 2020 онд хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирж байгаа 15-24 насны залуучууд 2010 оноос 54.6 (19.6%) мянгаар буурсан байна. Энэ нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин буурсны илэрхийлэл юм.

Цаашид анхаарах асуудлын нэг бол өмнөх тооллогын үр дүнтэй харьцуулахад 2020 онд 0-9 насны хүн ам өссөн нь 10 жилийн дараа хөдөлмөрийн зах зээлд шинээр орох залуучууд нэмэгдэхийг илэрхийлж байна. Мөн 50-59 насны бүлгийн хүн амын нийт ажиллах хүчинд эзлэх хувийн жин сүүлийн 10 жилд 6.1 пунктээр нэмэгдэж 15.1 хувь болсон нь ирэх жилүүдэд ахмад настны тэтгэвэр тогтоолгох хүн ам ихсэх хандлагатайг харуулж байна.

ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ОРОЛЦОО

Хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны нийт хүн амын 59.7 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 3.3 пунктээр өсжээ. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн ам (40.3%) 3.3 пунктээр буурчээ.

Ажиллах хүчний оролцооны түвшин хөдөөд 63.0 хувь байгаа нь хот, суурин газрынхаас 4.8 пунктээр бага байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байгаа бөгөөд байршлын хувьд мөн ажиглагдаж байна.

Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшнийг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад, 15-29 насны бүлэгт буурсан ч, 30, түүнээс дээш насанд нэмэгдсэн (50-59 насны бүлэгт хамгийн их өсөлттэй) байна.

Залуучуудын (15-24 нас) ажиллах хүчний оролцооны түвшин нь тухайн оронд боловсролын боломжууд хэр элбэг байгааг илтгэдэг бол ахимаг насныхны (55-64 эсхүл 65, түүнээс дээш насны бүлэг) ажиллах хүчний оролцооны түвшин нь ахмад ажилтнуудын тэтгэвэрт гарах хандлага, тэтгэврийн насны хүмүүст зориулсан нийгмийн хамгааллын сүлжээ байгаа эсэхийг илэрхийлдэг.

Сүүлийн 10 жилд манай улсад боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа 15-24 насны бүлгийн залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин буурч, 55, түүнээс дээш тэтгэвэрт гарах насны хүн амынх өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь залуучуудын боловсрол, сургалтад хамрагдалт нэмэгдэж байгаагийн илэрхийлэл юм. Харин ахмадуудын ажиллах хүчний оролцооны түвшин



нэмэгдэх нь ахмад настны тэтгэвэр тогтоолгосон иргэний орлого, нийгмийн хамгааллын хүртээмж бага, улмаар хөдөлмөр эрхлэх хэрэгцээ тулгарч байгаагийн илэрхийлэл байх талтай тул цаашид тусгайлан судлах нь зүйтэй.

Сүүлийн 1 жилийн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчдын ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн 5 жилийн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчдынхоос 3.8 пунктээр бага байна. Мөн сүүлийн 1 жилд шилжих хөдөлгөөнд орсон хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин сүүлийн 5 жилийнхтэй харьцуулахад бага (4.4 пунктээр) байна. Энэ нь шилжих хөдөлгөөнд оролцогчдын, ялангуяа гэр бүлээрээ шилжин суурьшиж буй эмэгтэйчүүдийн тухайн орон нутгийнхаа хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо бага байгаагийн илэрхийлэл байж болох юм. Иймд энэ нь цаашид тусгайлан судлахуйц дүр зураглал байна.

АЖИЛЛАГЧИД

Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амд ажиллагчдын эзлэх хувийн жин буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.8 хувь, хөдөөд 60.6 хувь, хот суурин газарт 50.5 хувь байна. Хөдөлмөрийн нас (15, түүнээс дээш нас)-ны 1.2 сая ажиллагчид байгаагийн 55.4 хувь нь үйлчилгээний, 24.5 хувь нь хөдөө аж ахуйн, 234.3 мянга (20.1%) нь аж үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

Ажиллагчдын тоог үндсэн 3 салбараар авч үзэхэд 2010 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид 18.8 хувиар, аж үйлдвэрлэлийн салбарт ажиллагчид 22.3 хувиар, үйлчилгээний салбарт ажиллагчид 35.1 хувиар тус тус өсжээ. Хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид хөдөөд ихэнх хувийг эзэлж байхад хотод үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллагчид дийлэнх хувийг эзэлж байна.

Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) сүүлийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. Тухайлбал, нийт ажиллагчдад цалин хөлстэй ажиллагчдын эзлэх хувийн жин 67.0 хувь болж 2010 оныхоос 10.8 пунктээр өссөн байна. Харин ажил олгогчийн эзлэх хувь 0.6 хувь болж 2010 оныхоос 1.9 пунктээр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувь 26.5 болж 1.4 пунктээр тус тус буурчээ. Нийт ажиллагчдад цалин хөлстэй ажиллагчдын эзлэх хувийн жин өсөх нь хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдах, нийгмийн хамгаалалд хамрагдах, хөдөлмөрлөх эрхээ эдлэх бололцоог нэмэгдүүлдэг сайн талтай ч цаашид цалин хөлстэй ажиллагчдын хэдэн хувь нь албан бус хөдөлмөр эрхэлж байгааг судлах нь зүйтэй. Мөн ажил олгогчийн хувийн жин буурч байгаагаар үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж чадахгүй байгааг илэрхийлж болох юм.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлагын хуваарилалт нь хөдөлмөр эрхлэлт дэх тэгш байдлыг хэмжиж буй чухал үзүүлэлт юм. Тогтвортой хөгжлийн Тавдугаар зорилгын хэрэгжилтийг найман үзүүлэлтээр хэмжинэ. Тэдгээрийн нэг



болох “Удирдах албан тушаалтай эмэгтэйчүүдийн хувийн жин” бүхий үзүүлэлт 5.5.2 нь эрх мэдэл, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог илэрхийлнэ. Улсын хэмжээнд удирдах албан тушаалд ажиллаж байгаа ажиллагчдад эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 48.2 хувь байна.

Мөн хөдөө аж ахуйн бус салбар дахь цалин хөлстэй ажиллагчдын эзлэх хувийн жин нь хөдөлмөр эрхлэх боломж хэр байгаа талаарх мэдээллийг өгдөг. Учир нь хөдөө аж ахуйн бус салбарт цалин хөлстэй ажиллагчид нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хөдөө аж ахуйн салбарт ажиллагчидтай харьцуулахад эдийн засгийн эрсдэлд өртөх нь бага байх талтай. Гэхдээ энэ байдал нь үндсэндээ байнгын ажиллагчдад хамааралтай. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор улсын хэмжээнд хөдөө аж ахуйн бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдэд байнгын цалин хөлстэй ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 82.1 хувь байна.

АЖИЛГҮЙДЭЛ

Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 оны тооллогын дүнгээр 9.9 хувь болж, 2010 онтой харьцуулахад 5.4 пунктээр буурчээ. Ажилгүйдлийн түвшин хотод 13.2 байгаа бол хөдөөд 3.7 байна. Мөн сүүлийн 1 жилийн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын ажилгүйдлийн түвшин амьдралынхаа турш оролцоогүй болон сүүлийн 5 жилийн хувьд шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын ажилгүйдлийн түвшнээс өндөр байна. Энэ нь нэг талаас төв, суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэд хот, суурин газарт шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой. Иймд хот, суурин газар руу шилжих урсгал хөдөлгөөнийг тэнцвэржүүлэхийн тулд хөдөө, орон нутагт үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлж, дэд бүтцийг сайжруулах шаардлагатай нь харагдаж байна.

Залуучууд (15-24 насны)-ын ажилгүйдлийн түвшин 2010 онд 25.1 хувь байсан бол 2020 онд эрс буурч 6.0 хувь болсон эерэг үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч залуучуудын ажилгүйдлийн түвшин нь тэдний хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх зарим мэдээллийг л илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл залуучуудад тулгарч буй асуудлыг бүрэн илэрхийлж чадахгүй. Үүнийг бүрэн илэрхийлэхийн тулд Тогтвортой хөгжлийн зорилтын “Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих” гэсэн 8-р зорилгод “15-24 насны залуучуудад хөдөлмөр эрхлээгүй болон суралцаагүй байгаа залуучуудын эзлэх хувь” гэсэн 8.6.1-р шалгуур үзүүлэлтийг тусгасан. Эдгээр залуучууд нь хөдөлмөрийн зах зээлд үнэлэгдэх ур чадвар эзэмшээгүй байдаг тул энэ нь тэдний цаашид ажилд орох боломжийг бууруулдаг. Улсын хэмжээнд 15-24 насны залуучуудын 12.2 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байна.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМ ЗҮЙ




МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын суурин хүн ам 3 197 020, тэдгээрийн 3 174 565 нь Монгол Улсын харьяат, 22 418 нь гадаадын харьяат, 37 нь харьяалалгүй хүн байна.

Монгол Улсын харьяат хүн амын тоо 3 296.9 мянга байгаа нь 2010-2020 оны хооронд буюу сүүлийн 10 жилийн хугацаанд 542.2 мянган хүнээр өсжээ. Харин энэ хугацаанд Монгол Улсын суурин хүн амын тоо 549.5 мянган хүнээр өссөн байна.

Монгол Улсын суурин хүн амын 49.3 хувь эрэгтэйчүүд, 50.7 хувь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) 97.3 хувь болж, 2010 оны тооллогын түвшнээс 1.2 пунктээр буурсан нь суурин хүн амд эзлэх эмэгтэйчүүдийн хувь илүү байгаа ч сүүлийн 10 жилд буурч байгааг илэрхийлж байна.

ЗУРАГ 1.1. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМ, МЯНГАН ХҮНЭЭР, 2010, 2020 ОН



Хүн амын суурьшлыг хот, хөдөө, бүс нутгаар тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, бүс нутгийн болон орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болдог.

Өндөр хөгжилтэй улс оронд үйлдвэржих үйл явцтай холбогдон хот суурин газарт үйлдвэрийн газар бий болж, түүнийг дагасан шилжих хөдөлгөөн өрнөдөг. Монгол Улсын хувьд хот, суурин газар руу чиглэсэн шилжих хөдөлгөөн жилээс жилд эрчимжиж байгаа ч үйлдвэржилтээс үүдэлтэй эсэх нь эргэлзээтэй юм.

Сүүлийн 20 жилд Монгол Улсын хотын хүн амын өсөлт түүний өмнөх 30 (1969-2000 оны тооллого) жилийн өсөлттэй ойролцоо болж байна. 2020 оны байдлаар Монгол Улсын суурин хүн амын хувьд 3 хүний 2 нь төв, суурин газар амьдарч байна. Хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг дотоод шилжих хөдөлгөөний өсөлт бүрдүүлдэг. Нийслэл болон аймгийн төвүүдэд боловсрол, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээний чанар хөдөө орон нутгаас илүү байдгийн зэрэгцээгээр, манай орны нүүдлийн соёл иргэншилтэй холбоотой хот, суурин газарт хөдөөгөөс илүү үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх өөрөөр хэлбэл ажлын байр олох боломжтой байдаг.



Үүнтэй холбоотойгоор Улаанбаатар хот хүн амын нягтралаар хамгийн өндөр хэвээр байгаагийн зэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.

Монгол Улсын суурин хүн ам сүүлийн 2 тооллого хооронд Улаанбаатар хотод болон бүх аймгуудад өссөн ч нийт суурин хүн амд тухайн аймгийн хүн амын эзлэх хувийн жин зарим аймагт буурсан байна.

Улаанбаатар хот хэдийгээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг ч 2020 онд нийт суурин хүн амын 45.9 хувь нь оршин суух болж, 2010 оноос 2.3 пунктээр нэмэгдсэн байна. Түүнчлэн Сүхбаатар аймгийн нийт суурин хүн амын эзлэх хувь 0.1 пунктээр нэмэгдсэн, Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Дундговь, Говьсүмбэр аймгуудад өөрчлөлтгүй, бусад аймгуудын хувьд 0.1-0.3 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1.1. СУУРИН ХҮН АМ, ХҮН АМЫН НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	2010			2020		
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	хүн/км ²	мян.хүн	Дүнд эзлэх хувь	хүн/км ²
БҮГД	2 647 545	100.0	1.7	3 197 020	100.0	2.0
Архангай	84 078	3.2	1.5	94 324	2.9	1.7
Баян-Өлгий	85 232	3.2	1.9	103 908	3.2	2.3
Баянхонгор	75 690	2.9	0.7	88 008	2.7	0.8
Булган	53 065	2.0	1.1	61 344	1.9	1.3
Говь-Алтай	53 223	2.0	0.4	57 479	1.8	0.4
Дорноговь	57 930	2.2	0.5	69 859	2.2	0.6
Дорнод	68 873	2.6	0.6	82 020	2.6	0.7
Дундговь	38 543	1.5	0.5	46 698	1.5	0.6
Завхан	64 924	2.4	0.8	72 307	2.3	0.9
Өвөрхангай	100 444	3.8	1.6	115 737	3.6	1.8
Өмнөговь	60 855	2.3	0.4	69 858	2.2	0.4
Сүхбаатар	51 091	1.9	0.6	62 884	2.0	0.8
Сэлэнгэ	95 804	3.6	2.3	107 755	3.4	2.6
Төв	83 838	3.2	1.1	92 409	2.9	1.2
Увс	72 906	2.7	1.0	82 941	2.6	1.2
Ховд	76 252	2.9	1.0	88 078	2.8	1.2
Хөвсгөл	114 331	4.3	1.1	134 318	4.2	1.3
Хэнтий	65 335	2.5	0.8	77 320	2.4	1.0
Дархан-Уул	90 642	3.4	27.5	102 171	3.2	31.0
Орхон	87 118	3.3	108.9	104 032	3.2	130.0
Говьсүмбэр	13 081	0.5	2.4	17 445	0.5	3.2
Улаанбаатар	1 154 290	43.6	245.6	1 466 125	45.9	311.9



ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын насны бүтэц нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Тухайн орны ажиллах хүчний тоо хэмжээ, өөрчлөлтөд хүн амын насны бүтэц ихээхэн нөлөөлдөг.

Суурин хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогоос 4.1 пунктээр өссөн нь төрөлт нэмэгдсэнийг харуулж байна. Мөн 65, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн жин 2010 оноос 0.4 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 1.2. СУУРИН ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Хүйсийн харьцаа ¹
	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	
БҮГД	3 197 020	100.0	1 576 930	100.0	1 620 090	100.0	97.3
0-4	383 259	12.0	196 803	12.5	186 456	11.5	105.5
5-9	368 314	11.5	188 352	11.9	179 962	11.1	104.7
10-14	274 874	8.6	140 208	8.9	134 666	8.3	104.1
15-19	216 767	6.8	110 141	7.0	106 626	6.6	103.3
20-24	225 385	7.1	113 271	7.2	112 114	6.9	101.0
25-29	259 199	8.1	130 143	8.3	129 056	8.0	100.8
30-34	286 850	9.0	143 491	9.1	143 359	8.9	100.1
35-39	239 794	7.5	119 621	7.6	120 173	7.4	99.5
40-44	215 218	6.7	106 169	6.7	109 049	6.7	97.4
45-49	191 657	6.0	93 162	5.9	98 495	6.1	94.6
50-54	162 440	5.1	76 257	4.8	86 183	5.3	88.5
55-59	141 166	4.4	64 238	4.1	76 928	4.7	83.5
60-64	96 226	3.0	41 768	2.7	54 458	3.4	76.7
65-69	55 343	1.7	22 808	1.4	32 535	2.0	70.1
70+	80 528	2.5	30 498	1.9	50 030	3.1	61.0

Тайлбар: *100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ


Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүснэ гэж заасан хэдий ч олон улсын түвшинд харьцуулахуйц байдлыг хангах үүднээс хүүхдэд 0-14, өндөр настанд 65, түүнээс дээш настай хүн амыг хамруулж хүн ам зүйн ачааллыг тооцсон.

Хүн ам зүйн ачаалал нь 15-64 насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15-аас доош, 65, түүнээс дээш насны хүн ам) буюу хүүхэд, хөгшдийн нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ. Монгол Улсын суурин хүн амын хувьд хүн ам зүйн ачаалал 2020 онд 57.1 болж 2010 оноос 10.4 пунктээр өсжээ.



Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны 5 хүн тутамд хөдөлмөрийн бус насны 3 хүн ногдож байна.

ЗУРАГ 1.2. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ*, 2010, 2020 ОН



Тайлбар: *Монгол Улсын суурин хүн амаар тооцсон.

ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ


Монгол Улсын Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль тогтоомжоор “ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүсэх” бөгөөд “эмэгтэй ажилтан өөрөө хүсвэл 55 наснаас өндөр насны тэтгэвэр авч болно” гэж заасан. Мөн Хөдөлмөрийн тухай хуульд “тэтгэвэр авагч ахмад настан хөдөлмөр эрхэлж болно” гэж заасан. Гэхдээ олон улсын хөдөлмөрийн статистикийн ойлголтын дагуу, олон улсын түвшинд харьцуулахуйц байдлыг хангах үүднээс хөдөлмөрийн насыг 15 ба түүнээс дээш насаар авч байна.

2020 оны тооллогоор Монгол Улсын суурин хүн амын 2 170 573 (67.9%) нь хөдөлмөрийн буюу 15, түүнээс дээш насны хүн ам байгаа нь 2010 оноос 264 604 хүнээр нэмэгдсэн ч дүнд эзлэх хувийн жингээр 4.1 пунктээр буурсан байна. Энэ нь өмнө нь дурдсанчлан 2020 онд Монгол Улсын 0-14 насны болон 65, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн жин 2010 оноос өссөнтэй холбоотой.

15, түүнээс дээш насны хүн амыг хөдөлмөрийн зах зээл дэх оролцооных нь хувьд ажиллах хүч (ажиллагчид болон ажилгүй хүн), ажиллах хүчнээс гадуурх (боломжит ажиллах хүч болон өргөтгөсөн ажиллах хүчнээс гадуурх хүн ам) хүн ам гэж ангилна.




ЗУРАГ 1.3. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, 2010, 2020 ОН



2020 оны тооллогоор Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын 59.7 хувийг ажиллах хүчинд багтаж буй хүн ам эзэлж байгаа бөгөөд 2010 оноос 3.3 пунктээр өссөн байна.

Хүн амын нас, хүйсийн 2020 оны суваргаас харахад дунд хэсгээрээ аажмаар өргөсөж байгаа нь хүн ам идэршиж байгааг харуулж байна.

ЗУРАГ 1.4. СУУРИН ХҮН АМ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НАС ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



2010 оны суваргаас харахад 5-14 насны бүлгийн хэсгээр нэлээд нарийссан байсан нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин буурсны илэрхийлэл бөгөөд улмаар 2020 оны суваргын 15-24 насны бүлгийн хэсгээр нарийсахад нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, 2020 онд хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирж байгаа 15-24 насны залуучууд 2010 оноос 54.6 (19.6%) мянгаар буурахад нөлөөлсөн байна.

2020 оны суваргаас харахад 0-9 насанд буюу суваргын суурь өргөн болсон нь сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин нэмэгдсэнийг, цаашид 10 жилийн дараа 10-19



насны бүлгийн хэсгээр нэлээд цүлхийж, хөдөлмөрийн зах зээлд шинээр орох залуучууд ихсэхийг илэрхийлж байна. Мөн 50-59 насны бүлгийн хэсгээр бага зэрэг өргөсөж, тухайн насны хүн амын нийт ажиллах хүчинд эзлэх хувийн жин сүүлийн 10 жилд 6.1 пунктээр нэмэгдэж 15.1 хувь болсон нь ирэх жилүүдэд ахмад настны тэтгэвэр тогтоолгох хүн ам ихсэх хандлагатайг харуулж байна.

Улс орны ажиллах хүчний бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлт нь хүн ам зүйн өөрчлөлттэй нягт уялдаатай бөгөөд уг өөрчлөлтийг дэлгэрэнгүй судлах нь улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог. Иймд дараагийн бүлгүүдэд ажиллах хүч, ажиллагчид, ажилгүй хүний тооны болон бүтцийн өөрчлөлтийг дэлгэрэнгүй судлахыг зорилоо.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

**ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН
ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО**



Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш нас (хөдөлмөрийн нас)-ны 2 170.6 мянган суурин хүн ам байгаагийн 1 051.6 мянга (48.4%) нь эрэгтэйчүүд, 1 119.0 мянга (51.6%) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны суурин хүн ам 2010 оноос 264.6 (13.9%) мянгаар нэмэгдлээ.

Хөдөлмөрийн насны хүн амын бүтцийн хувьд 1 296.8 (59.7%) мянга нь ажиллах хүч байгаа нь 2010 оноос 221.0 (20.5%) мянгаар, 873.8 (40.3%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байгаа нь 2010 оноос 43.6 (5.3%) мянгаар өссөн байна. Ажиллах хүчний 1 167.9 (90.1%) мянга нь ажиллагчид, 128.9 (9.9%) мянга нь ажилгүй хүн байна.

ХҮСНЭГТ 2.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2010, 2020 ОН

	2010	2020	$\frac{2020}{2010}$ %
15, түүнээс дээш насны хүн ам	1 905 969	2 170 573	113.9
Ажиллах хүч	1 075 780	1 296 781	120.5
Ажиллагчид	911 664	1 167 921	128.1
Ажилгүй хүн	164 116	128 860	78.5
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	830 189	873 792	105.3
Сургуульд сурдаг	300 494	327 237	108.9
Тэтгэвэрт	191 907	236 442	123.2
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	55 888	45 658	81.7
Гэрийн ажилтай	108 403	92 492	85.3
Тохирох ажил олдохгүй байгаа	121 519	103 680	85.3
Ажиллах сонирхолгүй	3 283	3 672	111.8
Бусад	48 695	64 611	132.7

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон. Уламжлалт тооллогын асуулгаар “Тооллогын товын үед хөдөлмөр эрхэлж байгаа эсэх, товоос өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн болон тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй боловч ер нь ажилтай хүнийг “Хөдөлмөр эрхэлдэг” гэж үзсэн. Харин бүртгэлд суурилан мэдээлэл боловсруулалтад Хүн ам, өрхийн мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон Гадаадын иргэн харьяатын газрын гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн сантай уялдуулан хөдөлмөр эрхэлдэг хүнийг гаргасан.

Ажилгүй хүн гэдгийг тодорхойлоход хүн амын тооллогын асуулгын хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан, мөн сүүлийн 30 хоногт цалин хөлстэй ажил хайх (бизнес эрхлэх) ямар нэгэн оролдлого хийсэн эсэхийг тодруулсан. Ажил хайж байгаа гэдэгт тооллогын товын өмнөх 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй бөгөөд хөдөлмөр



халамж, үйлчилгээний хэлтэс бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг хамааруулж, ажилгүйчүүдийг тодорхойлов.

ЗУРАГ 2.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН



АЖИЛЛАХ ХҮЧ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 1 296.8 мянга (59.7%) нь ажиллах хүч байгаагийн 686.2 мянга (52.9%) нь эрэгтэйчүүд, 610.6 мянга (47.1%) нь эмэгтэйчүүд байна.

Ажиллах хүчний 852.4 мянга (65.7%) нь хот, суурин газарт амьдарч байгаа нь хөдөөгийнхөөс 408.1 мянга буюу 31.5 пунктээр илүү байна.

Ажиллах хүчийг насны бүлгээр авч үзэхэд, 25-39 насанд хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд хүйсийн хувьд уг хандлага мөн хадгалагдаж байна. Манай улсад 1956-1989 оны хооронд эрүүл мэндийн салбар хурдацтай хөгжиж, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, нас баралтын түвшнийг бууруулах, төрөөс олон хүүхэдтэй эхчүүдэд тэтгэвэр, тэтгэмж олгох зэргээр төрөлтийг дэмжих шат дараатай арга хэмжээ авсан нь хүн амын өсөлт хамгийн оргил үедээ хүрч, хүн ам өсөхөд голлон нөлөөлсөн гэж үздэг.

Ажиллах хүчний 116.6 мянга (9.0%) нь 15-24 насны боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд, 1 066.0 мянга (82.2%) нь 25-54 насны ерөнхий ажиллах хүчнийхэн, 99.6 мянга (7.7%) нь 55-64 насны хүн ам, 14.5 мянга (1.1%) нь 65, түүнээс дээш насны хүн ам байна.



ХҮСНЭГТ 2.2. АЖИЛЛАХ ХҮЧ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, БАЙРШЛААР, 2020 ОН

Насны бүлэг	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 296 781	686 163	610 618	852 436	438 078	414 358	444 345	248 085	196 260
15-19	16 616	12 158	4 458	7 893	5 313	2 580	8 723	6 845	1 878
20-24	100 007	57 779	42 228	57 830	32 037	25 793	42 177	25 742	16 435
25-29	189 519	101 939	87 580	128 094	66 990	61 104	61 425	34 949	26 476
30-34	230 631	121 867	108 764	166 183	86 693	79 490	64 448	35 174	29 274
35-39	194 078	101 251	92 827	131 812	67 666	64 146	62 266	33 585	28 681
40-44	175 891	88 816	87 075	115 095	56 822	58 273	60 796	31 994	28 802
45-49	154 824	75 881	78 943	100 190	47 654	52 536	54 634	28 227	26 407
50-54	121 087	59 112	61 975	78 321	36 631	41 690	42 766	22 481	20 285
55-59	75 350	43 579	31 771	48 134	26 909	21 225	27 216	16 670	10 546
60-64	24 296	14 885	9 411	12 441	7 336	5 105	11 855	7 549	4 306
65+	14 482	8 896	5 586	6 443	4 027	2 416	8 039	4 869	3 170

Улсын хэмжээнд ажиллах хүчний ихэнх буюу 47.4 хувийг 25-39 насныхан эзэлж байгаа бөгөөд байршлаар авч үзэхэд, тухайн насны бүлгийн эзлэх хувийн жин хот, суурин газарт хөдөө, орон нутгийнхаас 1.2-5.0 пунктээр их, бусад насны бүлэгт 0.2-2.7 пунктээр бага байна.

Ажиллах хүчний хүйсийн ялгаа 15-19 насанд хамгийн их байгаа бөгөөд хөдөө, орон нутагт 15-19 насны 5 хүний 4 нь, хот, суурин газарт 10 хүн тутмын 7 нь эрэгтэйчүүд байна. Энэ нь эрэгтэйчүүдийн ерөнхий боловсролын сургууль төгссөний дараа шууд хөдөлмөр эрхэлдэгтэй нь их байгаатай холбоотой юм.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

Ажиллах хүчний оролцооны түвшин нь тухайн улсын хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэх эсхүл ажлын байр хайх замаар хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож буй хувь хэмжээг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх боломжтой ажиллах хүчний нийлүүлэлтийн хэмжээ хөдөлмөрийн насны хүн амтай харьцуулахад хэчнээн байгааг илэрхийлж гаргаж ирдэг.

Иймд уг үзүүлэлт нь тухайн улс орны хүний нөөцийн хэмжээ болон бүтцийг судлах, мөн ажиллах хүчний хэтийн нийлүүлэлтийг тооцоолоход голлох үүрэгтэй үзүүлэлт юм. Энэхүү мэдээлэл нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах, хүлээгдэж буй хөдөлмөрийн насыг хүйсээр тооцох, ажиллах хүч болон тэтгэвэрт гарах хүн амын түвшнийг тооцох зэрэгт ашиглагдахаас гадна нийгмийн хамгааллын системийн санхүүгийн төлөвлөлтөд чухал ач холбогдолтой болж өгдөг.

Мөн хүн амын бүлгүүд хөдөлмөрийн зах зээл дээр хэрхэн өөрчлөгдөж буйг ойлгоход ашиглагддаг. Ажиллах хүчний түвшин болон оролцооны хэв маяг нь хөдөлмөр эрхлэх боломжууд болон орлогын эрэлт хэрэгцээнээс шалтгаалдаг хэдий ч хүн амын тодорхой бүлэг хооронд ялгаатай байх талтай. Жишээлбэл,



эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин бүх талаараа буюу насны бүлэг, гэр бүлийн байдал, боловсролын түвшний хувьд эрэгтэйчүүдийнхээс их ялгаатай байдаг. Түүнчлэн хот, хөдөөгийн хүн амын оролцооны түвшин ч гэсэн их зөрүүтэй байдаг.

Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 59.7 хувьд хүрч 2010 оныхоос 3.3 пунктээр өссөн байна. Хүйсийн хувьд ялгаатай байдлыг авч үзэхэд эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс 10.7 пунктээр бага (хотод 9.7 пунктээр, хөдөөд 12.5 пунктээр) байна.


ХҮСНЭГТ 2.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, 2010, 2020 ОН

	2010	2020	$\frac{2020}{2010}$ %
15, түүнээс дээш насны хүн ам	1 905 969	2 170 573	113.9
Ажиллах хүч	1 075 780	1 296 781	120.5
Ажиллах хүчний оролцооны түвшин	56.4	59.7	

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР

Сүүлийн 2 тооллогын дүнгээс харахад, 2010 онд 35-39 насны бүлгийн хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн их буюу 77.6 хувь байсан бол 2020 онд 40-44 насны бүлэгт хамгийн их буюу 81.7 хувьд хүрсэн байна.

ЗУРАГ 2.2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН



Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшнийг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад, 15-29 насны бүлэгт буурч, 30, түүнээс дээш насанд нэмэгдсэн байна. Тухайлбал, ажиллах хүчний оролцооны түвшин 50-59 насны бүлэгт (17.1 пункт) хамгийн их өсөлттэй, 20-24 насан (10.8 пункт)-д хамгийн их бууралттай байна.



Ажиллах хүчний оролцооны түвшин 15-29 насны бүлэгт бага байгаа нь эдгээр насны бүлэгт хамаарах хүн амын ихэнх ажиллах хүчнээс гадуурх хүн амд хамрагдан, тэдгээрийн 78.0 хувь нь суралцдаг гэсэн шалтгаантай байгаатай холбоотой юм. Харин 30-49 насныхны хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож байхад 50-54 насныхны оролцоо аажмаар, 55, түүнээс дээш насныхны оролцоо эрчимтэй буурч байгаа нь ажиллах хүчний өсөлт, бууралтад хүн амын насны бүтэц чухал үүрэг гүйцэтгэдгийг илэрхийлж байна.

Сүүлийн 2 тооллогын дүнгээс харахад, эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 15-19 насанд харьцангуй доогуур байснаа 25-44 насанд хамгийн их болж, 45-54 нас хүртэл аажим, 55, түүнээс дээш насанд илүү хурдан буурч байна.

Мөн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онтой харьцуулахад бүх насны бүлэгт 1.5-35.9 пунктээр өссөн бол эмэгтэйчүүдийнх бүх насны бүлэгт 1.9-39.1 пунктээр буурсан байна.


ХҮСНЭГТ 2.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	2010	2020	2010	2020	2010	2020
БҮГД	56.4	59.7	52.3	65.3	66.1	54.6
15-19	14.4	7.7	9.6	11.0	27.6	4.2
20-24	55.2	44.4	48.3	51.0	76.8	37.7
25-29	75.1	73.1	72.2	78.3	81.6	67.9
30-34	76.9	80.4	74.4	84.9	82.0	75.9
35-39	77.6	80.9	75.2	84.6	82.5	77.2
40-44	77.0	81.7	74.7	83.7	81.8	79.8
45-49	72.2	80.8	69.5	81.5	78.3	80.1
50-54	58.5	74.5	55.1	77.5	66.0	71.9
55-59	36.3	53.4	32.0	67.8	45.8	41.3
60-64	14.9	25.2	11.9	35.6	22.0	17.3
65+	5.2	10.7	3.4	16.7	8.8	6.8

Эмэгтэйчүүдийн оролцооны түвшин 20-24 насанд эрэгтэйчүүдийнхээс 13.3 пунктээр бага байгаа нь тухайн насны их, дээд сургуульд суралцагчдад эмэгтэйчүүд илүү байгаатай холбоотой. Мөн 25-39 насанд 7.4-10.4 пунктээр бага байгаа бол 40-54 насанд хүйсийн зөрүүтэй байдал багасаж байна.



ЗУРАГ 2.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Энэ нь амьдралынхаа энэхүү мөчлөг (25-39 нас)-т эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх, асрах зорилгоор ажиллах хүчнээс гардаг бөгөөд хүүхдүүд нь томрохын хирээр тэдгээрийн багахан хувь нь эргэн хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож, ажиллах хүчний эгнээнд нэгддэгтэй холбоотой. Түүнчлэн нийт хүн амд 0-9 насны хүүхдийн эзлэх хувийн жин 2010 оноос 4.4 пунктээр өссөн нь төрөлт нэмэгдсэний илэрхийлэл юм.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨГӨӨР

Ажиллах хүчний оролцооны түвшин хот, суурин газарт 58.2 хувь байгаа нь хөдөө орон нутаг (63.0%)-ийнхаас 4.8 пунктээр бага (эрэгтэйчүүдийнх 5.8 пунктээр, эмэгтэйчүүдийнх 3.0 пунктээр) байна.

ХҮСНЭГТ 2.5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Улсын дүн		Хот		Хөдөө	
	2000	2020	2010	2020	2010	2020
Ажиллах хүчний оролцооны түвшин	56.4	59.7	52.3	58.2	66.1	63.0
Ажиллах хүч	1 075 780	1 296 781	695 900	852 436	379 880	444 345
15, түүнээс дээш насны хүн ам	1 905 969	2 170 573	1 331 679	1 464 947	574 290	705 626

Ажиллах хүчний оролцооны түвшнийг байршлаар, 2010 оны тооллогын үр дүнтэй харьцуулахад, хотын ажиллах хүчний оролцооны түвшин 5.9 пунктээр нэмэгдсэн байхад хөдөөд 3.2 пунктээр буурсан байна.




Насны бүлгийн хувьд авч үзэхэд, 15-29 насанд хот (0.8-6.6 пунктээр), хөдөөд (4.7-28.2 пунктээр) адилхан буурсан, 30-аас дээш насанд хотод (3.5-18.0 пунктээр), хөдөөд (2.2-17.1 пунктээр) тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2.6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БАЙРШЛААР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд		Хот		Хөдөө	
	2010	2020	2010	2020	2010	2020
БҮГД	56.4	59.7	52.3	58.2	66.1	63.0
15-19	14.4	7.7	9.6	5.9	27.6	10.4
20-24	55.2	44.4	48.3	41.8	76.8	48.5
25-29	75.1	73.1	72.2	71.4	81.6	76.9
30-34	76.9	80.4	74.4	79.0	82.0	84.1
35-39	77.6	80.9	75.2	79.0	82.5	85.3
40-44	77.0	81.7	74.7	79.6	81.8	86.1
45-49	72.2	80.8	69.5	78.3	78.3	85.7
50-54	58.5	74.5	55.1	72.0	66.0	79.6
55-59	36.3	53.4	32.0	49.9	45.8	60.8
60-64	14.9	25.2	11.9	18.9	22.0	39.2
65+	5.2	10.7	3.4	6.9	8.8	19.0

Насны бүлгээрх ажиллах хүчний оролцооны түвшин байршлын хувьд хот суурин газарт хөдөө орон нутгийнхаас бага байгаа бөгөөд 15-19 насны бүлэгт хамгийн бага буюу 4.5 пункт, 60-64 насанд хамгийн их буюу 20.3 пункт зөрүүтэй байна.

ЗУРАГ 2.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БАЙРШЛААР, 2020 ОН



Хөдөө орон нутагт ажиллах хүчний оролцооны түвшин өндөр байгаа нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилтын салбарт хөдөөгийн ажиллагчид хамгийн өндөр



хувийг эзэлж байгаатай, тэр дундаа өрхийн аж ахуйд суурилсан нүүдлийн мал аж ахуй эрхлэлттэй холбоотой.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР


Энэхүү дэд бүлэгт боловсролын түвшин дэх ажиллах хүчний оролцооны түвшнийг авч үзэхдээ зөвхөн Монгол Улсын харьяат суурин хүн амын хүрээнд авсан болно.

Ажиллах хүчний оролцооны түвшин боловсролын түвшний хувьд мэргэжлийн анхан шатны боловсролоос дээш боловсролтой хүмүүсийн хувьд ихэссэн байна. Энэ нь хүн амын бүх насны бүлэгт, ялангуяа 15-44 насны хүн амын хувьд бүрэн дундаас доош боловсролтой хүн амын эзлэх хувийн жин 2010 онтой харьцуулахад буурсан бол эсрэгээрээ бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой хүн амын эзлэх хувийн жин өссөнтэй холбоотой.

Хүйсээр авч үзэхэд, бүх шатны боловсролын түвшинд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс илүү байна. Тухайлбал, дээд боловсролын түвшинд хамгийн бага буюу 6.0 пунктээр, бага боловсролын түвшинд хамгийн их буюу 27.0 пунктээр илүү байна.

Улсын хэмжээнд боловсролтой эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин боловсролтой эмэгтэйчүүдийнхээс 10.5 пунктээр, боловсролгүй эрэгтэйчүүдийнх боловсролгүй эмэгтэйчүүдийнхээс 18.5 пунктээр их байна.

ЗУРАГ 2.5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, 2020 ОН





Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшлэх тутам энэхүү ялгаа нь багассан байна. Энэ нь нөгөө талаараа эрэгтэйчүүд бүрэн дунд болон түүнээс доош түвшний боловсрол эзэмшээд шууд хөдөлмөр эрхлэх нь их байгаатай холбоотой байх талтай. Ялангуяа хөдөө орон нутагт суурь болон түүнээс доош боловсролын түвшинтэй эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өндөр байгаа нь нүүдэлчин мал аж ахуй эрхлэлттэй холбоотой.

ХҮСНЭГТ 2.7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БАЙРШИЛ, ХҮЙС, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН

	Бүгд	Боловсролтой	Үүнээс: Боловсролын түвшнээр						Боловсролгүй
			Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	
БҮГД	59.6	60.0	76.7	56.4	66.6	54.4	45.5	52.7	41.7
Эрэгтэй	65.1	65.4	80.2	67.8	72.3	62.0	52.0	65.3	50.2
Эмэгтэй	54.5	54.9	74.3	47.9	59.7	46.4	37.7	38.3	31.7
ХОТ	58.1	58.5	76.3	54.6	63.0	53.1	28.2	25.9	23.7
Эрэгтэй	63.1	63.5	80.4	66.9	70.1	61.0	34.5	37.8	30.3
Эмэгтэй	53.6	54.0	73.6	45.8	54.8	44.6	21.0	15.1	16.5
ХӨДӨӨ	62.8	63.2	78.3	62.5	72.3	58.0	59.1	63.0	54.2
Эрэгтэй	68.9	69.1	79.3	71.2	75.9	65.0	65.4	74.3	63.2
Эмэгтэй	56.6	57.1	77.7	55.8	67.9	51.3	51.3	48.8	43.0


Тодорхой түвшний боловсрол эзэмшсэн хүн амаас бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинтэй хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин бусад боловсролтой хүн амынхаас харьцангуй бага байна. Бага боловсролтой эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин тухайн түвшний боловсролтой эрэгтэйчүүдийнхээс нэлээд доогуур байгаа нь хот (22.7 пунктээр), хөдөөгийн (25.5 пунктээр) аль алинд адил байна.

15-19 насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин бусад насны бүлгийн хүмүүсийнхээс бага байгаа нь энэ насныхан суралцаж байдагтай холбоотой. Тусгай мэргэжлийн дунд, техникийн болон мэргэжлийн, бүрэн дунд, суурь боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцоо 40-44 насанд, дээд боловсролтой хүн амынх 45-49 насанд, бага боловсролтой хүн амынх 30-39 насанд, боловсролгүй хүн амынх 35-39 насанд өндөр байна.



ЗУРАГ 2.6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, 2020 ОН

%




Эмэгтэйчүүдийн хувьд, дээд, суурь, бага боловсролтой эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 15-24 нас хүртэл эрс өсөж, 25-44 насны бүлэгтжигд өсөлттэй, 45-59 насны бүлэгт аажим буурч, 60, түүнээс дээш насныханд эрчимтэй буурсан байна. Боловсролгүй эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 15-20 насанд эрс, 20-39 насанд аажим өсөж, 40-49 насанд аажим буурсан ч эргэн 50-54 насанд аажим нэмэгдэн, 55-аас дээш насанд тасралтгүй буурсан нь боловсрол эзэмшсэн хүмүүсийнхээс өөр дүр зураг харагдаж байна. Өөрөөр хэлбэл, боловсрол эзэмшсэн хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин тодорхой насны бүлэг хүртэл тасралтгүй өсөж байгаад мөн тасралтгүй буурсан байна.

Дээд, тусгай мэргэжлийн дунд, техник болон мэргэжлийн, суурь боловсролтой эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин нь 25-29 насны бүлэгт ойролцоо буюу давхцаж байгаа нь дараах зургаас харагдаж байна.




ЗУРАГ 2.7. ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, 2020 ОН



Дээд болон бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн оролцоо 25-49 насны бүлэгт аажим өсөж, 50, түүнээс дээш насанд буурсан бол бусад боловсролын түвшинтэй эмэгтэйчүүдийн оролцоо 25-44 насанд аажмаар өсөж, 45-аас дээш насанд буурсан байна.

ЗУРАГ 2.8. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, 2020 ОН





АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН ГЭР БҮЛИЙН БАЙДЛААР


Энэхүү дэд бүлэгт гэрлэлтийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшнийг авч үзэхдээ зөвхөн Монгол Улсын харьяат суурин хүн амын хүрээнд авсан болно.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулиар 18 нас хүрсэн хүн гэрлэх ёстой боловч амьдралд 18-аас доош насны хүмүүс гэрлэх тохиолдол цөөнгүй байдаг. Олон улсын аргачлалын дагуу 15 наснаас эхлэн гэр бүлийн байдлыг асуусан бөгөөд гэрлэлтийн байдлыг 15, түүнээс дээш насаар гаргав.

Улсын хэмжээнд батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцооны түвшин (71.8%) хамгийн өндөр байгаа бөгөөд хүйсийн хувьд (эрэгтэйчүүдийнх 77.3%, эмэгтэйчүүдийнх 66.6%) мөн хадгалагдаж байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин бэлэвсэн хүмүүсийн дунд хамгийн бага (28.1%) байгаа нь ерөнхийдөө эдгээр хүмүүс голдуу өндөр настай, түүнчлэн тэжээж, тэтгэх насанд хүрсэн хүүхдүүдтэй байдагтай, мөн огт гэр бүл болоогүй хүн амынх (41.7%) бага байгаа нь эдгээр хүмүүсийн ихэнх нь 25-аас доош насны сургуульд суралцаж байгаа залуучууд байгаатай холбоотой.

ЗУРАГ 2.9. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, 2020 ОН



Тайлбар: * - Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүнийг оруулсан.

** - Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан хүнийг оруулсан.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР

Шилжих хөдөлгөөн нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтөд голлон нөлөөлдөг хүчин зүйл юм. Сүүлийн 30 гаруй жилд хүн амын дотоод, гадаад шилжих хөдөлгөөн эрчимжиж, аймаг, нийслэл, бүс нутгийн хүн амын тоо, бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжилд хүчтэй нөлөөлж байна. Монгол Улс нь зах зээлийн эдийн засгийн



харилцаанд шилжсэн үеэс гол төлөв хөдөөгөөс мэргэжил, боловсрол эзэмших шалтгаанаар төв суурин газар луу шилжих нь нэмэгдэв.

Шилжих хөдөлгөөнийг тодорхой цаг хугацаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үздэг. Байнга оршин сууж байсан газраасаа буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс (аймаг, нийслэл) өөр газар луу шилжсэн, шилжиж ирсэн газартаа 6, түүнээс дээш сарын хугацаагаар суурьшин сууж байгаа хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үздэг.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор шилжих хөдөлгөөн буюу шилжигчдийг тодорхойлохдоо тооллогын товын үед:

- төрсөн нутгаасаа өөр газар амьдарч байгаа;
- таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газар;
- нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан газар гэсэн гурван үндсэн хугацаагаар авсан.

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний мэдээллийг 10 хувийн түүврийн мэдээлэлд үндэслэн гаргасан бол сүүлийн 1 болон 5 жилийн шилжих хөдөлгөөний мэдээллийг бүртгэлд суурилсан аргаар буюу Хүн ам, өрхийн мэдээллийн санд үндэслэн тооцсон болно.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 23.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 9.7 пунктээр, сүүлийн 5 жилийнх 8.2 пунктээр, сүүлийн 1 жилийнх 1.5 пунктээр тус тус буурчээ.

Төрснөөс хойших дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчдын ажиллах хүчний оролцооны түвшин 2010 оноос 10.5 пунктээр, сүүлийн 5 жилийнх 12.6 пунктээр, сүүлийн 1 жилийнх 2.9 пунктээр өссөн байна. 2020 оны байдлаар төрснөөс хойших болон сүүлийн 5 жилийн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчдын ажиллах хүчний оролцооны түвшин харьцангуй ойролцоо буюу 0.5 пунктын зөрүүтэй байгаа бол сүүлийн 1 жилийн хувьд оролцооны түвшин 3.8-4.3 пунктээр бага байна. Энэ нь шилжих хөдөлгөөнд оролцогчдын тухайн орон нутгийнхаа хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо бага байгаагийн илэрхийлэл юм. Мөн дараагийн бүлэгт шилжих хөдөлгөөнд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг авч үзсэн болно.




ХҮСНЭГТ 2.8. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2020 ОН

Хүйс	2010				2020			
	Бүгд	Төрс- нөөс хойш	Сүүлийн 5 жил	Сүүлийн 1 жил	Бүгд	Төрс- нөөс хойш	Сүүлийн 5 жил	Сүүлийн 1 жил
БҮГД	56.4	55.0	52.4	58.3	59.7	65.5	65.0	61.2
Эрэгтэй	63.0	60.7	61.5	64.8	65.3	70.5	72.1	70.2
Эрэгтэй	50.1	50.0	43.1	51.4	54.6	60.8	59.3	53.7

Сүүлийн 1 жилийн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд орсон эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 70.2 хувь, эмэгтэйчүүдийнх 53.7 хувьтай байна. Мөн уг хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд орсон эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин шилжих хөдөлгөөнд ороогүй эмэгтэйчүүдийнхээс 6.7 пунктээр бага байна.

ЗУРАГ 2.10. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙСЭЭР, СҮҮЛИЙН 1 ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010, 2020 ОН



Сүүлийн 5 жилийн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд орсон эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 72.1 хувь, эмэгтэйчүүдийнх 59.3 хувьтай байна.



ЗУРАГ 2.11. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙСЭЭР, СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2010, 2020 ОН



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦОО

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын онцлогоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Эрүүл мэндийн яамны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сангуудыг уялдуулж гаргасан.

Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны суурин хүн ам (2 170.6 мянга)-ын 98.2 мянга (4.5%) нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлийн хэлбэртэй гэж тоологджээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 32.8 мянга (33.4%) нь хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож ажиллах хүчнийг бүрүүлж байгаа бөгөөд 31.1 мянга (94.6%) нь хөдөлмөр эрхэлж, 1.7 мянга (5.4%) нь цалин хөлс, орлого олох зорилготойгоор ажил хайж, хийхэд бэлэн байгаа ажилгүй хүн байна. Хөдөө орон нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцооны түвшин хот, суурин газрынхаас 23.0 пунктээр илүү байна.



ХҮСНЭГТ 2.9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН


	15, түүнээс дээш насны хүн ам	Ажиллах хүч	Үүнээс:		АХОТ*
			Ажиллагчид	Ажилгүйчүүд	
БҮГД	2 170 573	1 296 781	1 167 921	128 860	59.7
Хөгжлийн бэрхшээлгүй	2 065 111	1 208 675	785 490	341 394	58.5
Хөгжлийн бэрхшээлтэй	98 243	32 851	31 092	1 759	33.4
Харааны	11 883	5 057	4 780	277	42.6
Ярианы	2 831	940	916	24	33.2
Сонсголын	8 336	3 421	3 250	171	41.0
Үүнээс: Хөдөлгөөний	22 176	7 589	7 238	351	34.2
Сэтгэцийн	20 101	4 113	3 854	259	20.5
Бусад	27 639	10 178	9 575	603	36.8
Хавсарсан	5 277	1 553	1 479	74	29.4
ХОТ	1 464 947	852 436	740 007	112 429	58.2
Хөгжлийн бэрхшээлгүй	1 405 250	837 849	726 709	111 140	59.6
Хөгжлийн бэрхшээлтэй	59 697	14 587	13 298	1 289	24.4
Харааны	6 888	2 303	2 108	195	33.4
Ярианы	1 552	383	365	18	24.7
Сонсголын	5 195	1 647	1 519	128	31.7
Үүнээс: Хөдөлгөөний	12 808	3 243	2 991	252	25.3
Сэтгэцийн	11 847	1 391	1 194	197	11.7
Бусад	18 162	4 976	4 530	446	27.4
Хавсарсан	3 245	644	591	53	19.8
ХӨДӨӨ	705 626	444 345	427 914	16 431	63.0
Хөгжлийн бэрхшээлгүй	659 861	370 826	58 781	230 254	56.2
Хөгжлийн бэрхшээлтэй	38 546	18 264	17 794	470	47.4
Харааны	4 995	2 754	2 672	82	55.1
Ярианы	1 279	557	551	6	43.5
Сонсголын	3 141	1 774	1 731	43	56.5
Үүнээс: Хөдөлгөөний	9 368	4 346	4 247	99	46.4
Сэтгэцийн	8 254	2 722	2 660	62	33.0
Бусад	9 477	5 202	5 045	157	54.9
Хавсарсан	2 032	909	888	21	44.7

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцоог хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл, харааны бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцооны түвшин 42.6 хувь, сонсголын бэрхшээлтэй иргэдийнх 41.0 хувь байгаа нь хамгийн их байна. Энэ нь мөн хот, хөдөөгийн хувьд адил байна. Сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо хамгийн бага буюу 20.5 хувь байгаа нь мөн хот, хөдөөгийн хувьд адил байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний оролцооны түвшин хөгжлийн бүх бэрхшээлийн хувьд хөдөөд хот, суурин газрынхаас их байгаа ба уг зөрүү нь ярианы бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хамгийн бага буюу 18.9 пунктын зөрүүтэй, бусад хэлбэрийн хувьд 21.1-27.5 пунктын зөрүүтэй байна.



ЗУРАГ 2.12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, БАЙРШЛААР, 2020 ОН



АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ

Улсын хэмжээнд хөдөлмөрийн нас (15, түүнээс дээш)-ны суурин хүн амын 873.8 мянга буюу 40.2 хувь нь хөдөлмөрийн зах зээлд оролцохгүй байгаа ажиллах хүчнээс гадуурх (ажиллагч, ажилгүй хүнээс бусад) хүн ам байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам 2010 оноос 43.6 мянга (5.2%)-н хүнээр өссөн ч хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувийн жингээр 2010 оноос 3.3 пунктээр буурсан байна. Энэ нь 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо буюу ажиллах хүчний оролцооны түвшин ихэссэнийг илэрхийлж байна.


ХҮСНЭГТ 2.10. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, ШАЛТГААНААР, 2010, 2020 ОН

Шалтгаан	2010			2020			2020 / 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	830 189	347 139	483 050	873 792	365 404	508 388	105.3
Сургуульд сурдаг	300 494	136 696	163 798	327 237	151 765	175 472	108.9
Тэтгэвэрт	191 907	65 745	126 162	236 442	75 586	160 856	123.2
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	55 888	31 256	24 632	45 658	25 449	20 209	81.7
Гэрийн ажилтай	108 403	12 122	96 281	92 492	10 928	81 564	85.3
Тохирох ажил олдохгүй байгаа	121 519	71 856	49 663	103 680	62 303	41 377	85.3
Ажиллах сонирхолгүй	3 283	2 321	962	3 672	2 612	1 060	111.8
Бусад	48 695	27 143	21 552	64 611	36 761	27 850	132.7



Ажиллах хүчнээс гадуурх хүн амын өсөлтийг шалтгаанаар авч үзэхэд ахмад настны тэтгэвэрт гарсан хүн ам 44.5 мянга (23.2%)-аар, сургуульд сурдаг хүн ам 26.7 мянга (8.9%)-аар өссөн нь нөлөөлсөн байна. Харин насны бүлгээр авч үзэхэд, хамгийн их өсөлттэй байгаа нь 60, түүнээс дээш насанд 54.8 мянга (39.5%), 55-59 насанд 20.0 мянга (43.6%)-н хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2.13. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, ШАЛТГААН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 365.4 мянга (41.8%) нь эрэгтэйчүүд, 508.4 мянга (58.2%) нь эмэгтэйчүүд байна. Харин насны бүлгээр авч үзэхэд хамгийн их хувийг 15-19 насныхан (22.9%), 60-64 насныхан (22.1%), 20-24 насныхан (14.3%) эзэлж байгаа бол хамгийн бага хувийг 45-49 насныхан (4.2%) эзэлж байна.

Хүйсийн хувьд ялгаатай байдлыг насны бүлгээр авч үзэхэд бүх насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс их байгаа ба 15-19 насны бүлэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс 2.1 пунктээр их байсан бол 20-34 насны бүлэгт тасралтгүй өсөж 11.5-23.1 пунктээр, 35-49 насны бүлэгт аажмаар буурч 6.2-19.6 пунктын зөрүүтэй, 50-59 насны бүлэгт дахин өсөж 17.1-37.2 пунктын зөрүүтэй, 60, түүнээс дээш насанд 26.2 пунктын зөрүүтэй болжээ. Энэ нь эмэгтэйчүүд 20-29 насанд илүүтэйгээр боловсрол сургалтад хамрагддаг, 25-39 насанд хүүхэд төрүүлэх, асрах нь их байдаг, 40-49 насанд эргэн хөдөлмөрийн зах зээлд тодорхой бүлэг нь оролцдогтой, 50-аас дээш насанд ахмад настны тэтгэвэр тогтоолгодгийн илэрхийлэл юм.




ХҮСНЭГТ 2.11. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, БАЙРШЛААР, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020			2020 / 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	830 189	347 139	483 050	873 792	365 404	508 388	105.3
15-19	220 522	104 683	115 839	200 151	97 983	102 168	90.8
20-24	130 919	53 110	77 809	125 378	55 492	69 886	95.8
25-29	61 752	21 397	40 355	69 680	28 204	41 476	112.8
30-34	51 441	19 385	32 056	56 219	21 624	34 595	109.3
35-39	45 325	18 862	26 463	45 716	18 370	27 346	100.9
40-44	41 170	18 521	22 649	39 327	17 353	21 974	95.5
45-49	44 071	19 768	24 303	36 833	17 281	19 552	83.6
50-54	50 612	19 644	30 968	41 353	17 145	24 208	81.7
55-59	45 840	15 459	30 381	65 816	20 659	45 157	143.6
60+	138 537	56 310	82 227	193 319	71 293	122 026	139.5

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоогүй үндсэн шалтгаанд сургуульд сурдаг, ахмад настны тэтгэвэрт гарсан гэсэн хоёр шалтгаан орж байна.

Нийт эрэгтэйчүүдийн 41.4 хувь, эмэгтэйчүүдийн 34.3 хувь нь сургуульд суралцаж байгаа шалтгаантай, мөн нийт эрэгтэйчүүдийн 20.8 хувь, эмэгтэйчүүдийн 31.8 хувь өндөр настай буюу ахмад настны тэтгэвэрт гарсан шалтгаантай байна. Эмэгтэйчүүдийн хувьд 16.0 хувь нь гэрийн ажилтай гэж хариулсан нь, эрэгтэйчүүдийн 17.2 хувь нь тодорхой ажил олдохгүй байна гэсэн шалтгаан мөн их хувийг эзэлж байна.

ЗУРАГ 2.14. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, ШАЛТГААН, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН





Ажиллах хүчнээс гадуурх 10 хүн тутмын 7 нь хот, суурин газар, 3 нь хөдөөд оршин сууж байгаа нь хүйсийн хувьд, мөн 5 хүн тутмын 3 нь эмэгтэйчүүд байгаа нь хот, хөдөөгийн хувьд уг хандлага ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 2.12. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, ХОТ, ХӨДӨӨ,, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	873 792	365 404	508 388	612 511	254 393	358 118	261 281	111 011	150 270
15-19	200 151	97 983	102 168	125 050	62 038	63 012	75 101	35 945	39 156
20-24	125 378	55 492	69 886	80 615	35 640	44 975	44 763	19 852	24 911
25-29	69 680	28 204	41 476	51 247	19 929	31 318	18 433	8 275	10 158
30-34	56 219	21 624	34 595	44 066	16 115	27 951	12 153	5 509	6 644
35-39	45 716	18 370	27 346	35 006	13 547	21 459	10 710	4 823	5 887
40-44	39 327	17 353	21 974	29 543	12 832	16 711	9 784	4 521	5 263
45-49	36 833	17 281	19 552	27 687	12 973	14 714	9 146	4 308	4 838
50-54	41 353	17 145	24 208	30 386	12 860	17 526	10 967	4 285	6 682
55-59	65 816	20 659	45 157	48 277	15 554	32 723	17 539	5 105	12 434
60+	193 319	71 293	122 026	140 634	52 905	87 729	52 685	18 388	34 297

Ажиллах хүчнээс гадуурх хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин хотод хөдөөгийнхөөс 1.0 пунктээр их байна. Үүнийг насны бүлгээр авч үзэхэд, 15-19 насны болон 50, түүнээс дээш насны бүлэгт хөдөөгийн ажиллах хүчнээс гадуурх эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин хотынхоос 1.7-3.3 пунктээр их байгаа бол 20-49 насны бүлэгт 0.1-8.8 пунктээр бага байна. Ажиллах хүчнээс гадуурх суурин хүн амын 869.1 буюу 99.5 хувь нь Монгол Улсын харьяат хүн ам байгаагаас 37.2 хувь нь бүрэн дунд, 25.8 хувь нь суурь, 17.3 хувь нь дээд, 7.6 хувь нь бага, 5.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.6 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой, 2.8 хувь нь боловсрол эзэмшээгүй хүн байна. Бүрэн дунд болон суурь боловсролтой хүн амын дүнд эзлэх хувь өндөр байгаад ажиллах хүчнээс гадуурх хүн амд 15-24 насныхан хамгийн их (37.2%) хувийг эзэлж байгаа нөлөөлж байна.

Тохирох ажил олдохгүй байгаа шалтгаантай ажиллах хүчнээс гадуурх хүн амыг боловсролын түвшнээр авч үзэхэд, 43.3 хувь нь бүрэн дунд, 19.6 хувь нь суурь, 19.0 хувь нь дээд боловсролтой байна. Өөрөөр хэлбэл, тэдгээрийн 29.6 хувь нь тодорхой мэргэжил эзэмшсэн байх боловсролын түвшинтэй байхад 68.4 хувь нь ерөнхий боловсролын сургуулийн холбогдох боловсролын түвшинтэй, 2.0 хувь нь ямар нэгэн шатны боловсрол эзэмшээгүй байгаа нь анхаарал татаж байна.



ХҮСНЭГТ 2.13. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, ШАЛТГААН, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, 2020 ОН

Шалтгаан	Бүгд	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловс- ролгүй
БҮГД	100.0	17.3	5.7	3.6	37.2	25.8	7.6	2.8
Сургуульд сурдаг	100.0	9.7	0.5	1.2	41.3	42.1	3.8	1.4
Тэтгэвэрт	100.0	22.3	14.0	5.2	25.8	15.2	15.0	2.5
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	100.0	9.4	5.7	4.2	33.5	17.9	9.8	19.5
Гэрийн ажилтай	100.0	29.0	4.8	4.3	42.2	13.9	4.2	1.6
Тохирох ажил олдохгүй байгаа	100.0	19.0	4.6	6.0	43.3	19.6	5.5	2.0
Ажиллах сонирхолгүй	100.0	11.5	3.8	3.5	42.6	23.0	11.0	4.6
Бусад	100.0	23.5	4.8	4.6	43.3	15.8	5.4	2.6
ЭРЭГТЭЙ	100.0	13.9	4.3	3.9	38.0	29.7	7.1	3.1
Сургуульд сурдаг	100.0	7.5	0.6	1.5	38.8	45.4	4.6	1.6
Тэтгэвэрт	100.0	26.4	11.0	6.0	27.3	15.8	11.7	1.8
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	100.0	8.7	5.3	4.7	34.1	19.2	9.7	18.3
Гэрийн ажилтай	100.0	13.0	4.7	4.6	44.2	21.8	8.5	3.2
Тохирох ажил олдохгүй байгаа	100.2	14.7	4.3	6.1	44.8	21.8	6.3	2.2
Ажиллах сонирхолгүй	100.0	8.7	3.4	3.5	42.4	25.5	12.1	4.4
Бусад	100.0	17.6	4.5	4.8	45.7	18.1	6.4	2.9
ЭМЭГТЭЙ	100.0	19.7	6.8	3.4	36.6	23.0	7.9	2.6
Сургуульд сурдаг	100.0	11.5	0.5	1.0	43.5	39.3	3.1	1.1
Тэтгэвэрт	100.0	20.4	15.4	4.8	25.1	14.9	16.5	2.9
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	100.0	10.3	6.1	3.5	32.9	16.2	10.0	21.0
Гэрийн ажилтай	100.0	31.0	4.8	4.3	42.0	12.9	3.7	1.3
Тохирох ажил олдохгүй байгаа	100.0	25.6	5.0	5.9	41.1	16.4	4.3	1.7
Ажиллах сонирхолгүй	100.0	18.4	4.6	3.6	43.1	16.8	8.4	5.1
Бусад	100.0	31.2	5.0	4.4	40.2	12.8	4.3	2.1



ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЖИЛЛАГЧИД



АЖИЛЛАГЧИД, ТЭДГЭЭРИЙН БҮТЭЦ

Улсын хэмжээнд ажиллах хүчний 1 167.9 мянга (90.1%) нь ажиллагчид байгаагийн 617.4 мянга (52.9%) эрэгтэйчүүд, 550.5 мянга (47.1%) нь эмэгтэйчүүд байна. Ажиллагчид 2010 онтой харьцуулахад 256.2 мянган (28.1%) хүнээр, хүйсийн хувьд эрэгтэйчүүд 122.3 мянга (24.7%), эмэгтэйчүүд 133.9 мянга (32.2%)-аар нэмэгдсэн байна. Ажиллагчдын 740.0 мянга (63.4%) нь хот суурин газар, 427.9 мянга (36.6%) нь хөдөө орон нутагт оршин суугаа бөгөөд ажиллагчдын тоо бүс нутгаар нэлээд ялгаатай байна.

ХҮСНЭГТ 3.1. АЖИЛЛАГЧИД, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Байршил, бүс	2010			2020			2020% 2010
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	911 664	495 101	416 563	116 7921	617 419	550 502	128.1
Хот	581 329	306 728	274 601	74 0007	378 581	361 426	127.3
Хөдөө	330 335	188 373	141 962	42 7914	238 838	189 076	129.5
Баруун	162 869	93 382	69 487	14 1851	77 095	64 756	87.1
Хангай	62 195	34 508	27 687	24 3702	130 119	113 583	391.8
Төв	110 803	61 104	49 699	19 8448	109 420	89 028	179.1
Зүүн	184 274	98 586	85 688	8 1959	45 366	36 593	44.5
Улаанбаатар	391 523	207 521	184 002	501 961	255 419	246 542	128.2

Ажиллагчдын 502.0 мянга (43.0%) нь Улаанбаатар хотод, 243.7 мянган (20.9%) нь Хангайн бүсэд, 198.4 мянга (17.0%) Төвийн бүсэд, 141.8 мянга (12.1%) нь Баруун бүсэд, 82.0 мянга (7.0%) нь Зүүн бүсэд амьдарч байна. Ажиллагчид 2010 оноос өсөхөд Хангайн бүсэд амьдарч буй ажиллагчид 181.5 мянга (3.9 дахин), Төвийн бүсэд 87.6 мянга (79.1%), Улаанбаатар хотод 110.4 мянга (28.2%)-аар өссөн нь нөлөөлсөн ч Зүүн бүсэд амьдарч буй ажиллагчид 2010 онтой харьцуулахад 102.3 мянга (55.5%), Баруун бүсэд 21.0 мянга (12.9%)-аар буурсан байна.

АЖИЛЛАГЧДЫН НАСНЫ БҮЛЭГ

Ажиллагчид 2010 онтой харьцуулахад өссөн ч, насны бүлгээр авч үзэхэд сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна. Нийт ажиллагчдад боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа 15-24 насны залуучуудын эзлэх хувь 2010 онтой харьцуулахад 6.9 пунктээр, 25-29 насныхан 2.3 пунктээр буурсан байна. Энэ нь 15-24 насны хүн ам 2010 онтой харьцуулахад 107.7 мянга (19.6%)-аар буурч, хөдөлмөрийн насны хүн амд 15-24 насны бүлгийнхний эзлэх хувийн жин 8.5 пунктээр буурсантай холбоотой. Өөрөөр хэлбэл, 1990-ээд оны эхэн үеэс 2006 он хүртэлх хугацаанд төрөлтийн түвшин бага байснаар тайлбарлагдана. Нөгөөтэйгүүр,



залуучуудын сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеэс нэмэгдсэн нь энэхүү бууралтад нөлөөлсөн байх талтай.


Харин ажиллагчдад 30, түүнээс дээш насныхны эзлэх хувийн жин 2010 онтой харьцуулахад өссөн байна. Тухайлбал, 55-59 насны бүлэгт хамгийн их буюу 2.9 пункт, 50-54 насны бүлэгт 1.9 пункт, 30-34 насны бүлэгт болон 60, түүнээс дээш насны ажиллагчдын эзлэх хувийн жин тус бүр 1.8 пунктээр өссөн байна. Энэ нь сүүлийн 10 жилд хөдөлмөрийн насны суурин хүн амд 30, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн жин өссөн бөгөөд 55-59 насны бүлэгт хамгийн их буюу 2.7 пунктээр, 60-64 насны бүлэгт 1.8 пунктээр, 30-34 насны бүлэгт 1.5 пунктээр, 50-54 насны бүлэгт 1.1 пунктээр, 65-69 насны бүлэгт 0.5 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 3.2. АЖИЛЛАГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020			2020/2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	911.7	495.1	416.6	1 168.0	617.5	550.5	128.1
15-19	25.6	18.7	6.9	15.9	11.7	4.2	62.1
20-24	122.9	72.7	50.2	93.7	54.4	39.3	76.2
25-29	155.5	86.0	69.5	172.9	93.2	79.7	111.2
30-34	145.1	77.8	67.3	206.6	108.7	97.9	142.4
35-39	135.1	69.2	65.9	173.7	90.0	83.7	128.6
40-44	120.8	59.9	60.9	157.1	78.4	78.7	130.0
45-49	102.7	50.6	52.1	137.8	67.0	70.8	134.2
50-54	66.4	34.8	31.6	107.3	52.4	54.9	161.6
55-59	25.0	16.9	8.1	65.0	38.5	26.5	260.0
60+	12.6	8.5	4.1	38.0	23.2	14.8	301.6

Ажиллагчдын 9.4 хувь нь 15-24 насны залуучууд (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуус), 81.8 хувь нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насны бүлгийнхэн), 7.6 хувь нь 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа), 1.2 хувь нь 65, түүнээс дээш насныхан байна.

ЗУРАГ 3.1. АЖИЛЛАГЧИД, НАСНЫ БҮЛГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН




Хүйсийн хувьд 40-54 насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 0.3-3.8 мянга (0.2-2.8 пункт)-аар их байгаа бол бусад насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 6.3-15.1 мянга (7.5-47.2 пункт)-аар их байна.

Эмэгтэй ажиллагчдын 7.9 хувь нь 15-24 насны залуучууд, 84.6 хувь нь ерөнхий ажиллах хүчний буюу 25-54 насныхан, 7.5 хувь нь 55, түүнээс



дээш насныхан байгаа бол эрэгтэйчүүдийн 10.7 хувь нь 15-24 насныхан, 79.4 хувь нь 25-54 насныхан, 9.9 хувь нь 55 ба түүнээс насныхан байна. Энэ нь залуу болон ахмад настай эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс их байгааг илэрхийлж байна.

ЗУРАГ 3.2. АЖИЛЛАГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



АЖИЛЛАГЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нийт ажиллагчдын 98.6 хувь нь боловсролтой, үүнээс эрэгтэйчүүдийн 98.3 хувь, эмэгтэйчүүдийн 99.0 хувь нь ямар нэг түвшний боловсрол эзэмшжээ. Арван ажиллагч тутмын дөрөв нь дээд, гурав нь бүрэн дунд боловсролтой байна. Эмэгтэйчүүдийн хувьд хоёр ажиллагч тутмын нэг нь дээд, дөрвөн ажиллагч тутмын нэг нь бүрэн дунд боловсролтой байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд арван ажиллагч тутмын гурав нь бүрэн дунд, мөн гурав нь дээд боловсролтой байна.

Ажиллагчдын боловсролын түвшин дэх хүйсийн ялгаатай байдал дээд боловсролын түвшинд их ажиглагдаж байгаа буюу нийт эмэгтэй ажиллагчдад дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 48.5 хувь байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 17.6 пунктээр их байна. Эмэгтэй ажиллагчдад дээд боловсролтой (48.5%) болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой (5.2%) эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс 0.3-17.6 пунктээр их байгаа бол бусад боловсролын түвшинд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 0.7-6.7 пунктээр их байна.

2010 онтой харьцуулахад техникийн болон мэргэжлийн боловсролтой ажиллагчид 72.3 хувиар, дээд боловсролтой ажиллагчид 69.9 хувиар, суурь




боловсролтой ажиллагчид 16.3 хувиар, бүрэн дунд боловсролтой ажиллагчид 14.8 хувиар өссөн бол боловсролгүй ажиллагчид 49.3 хувиар, тусгай мэргэжлийн боловсролтой ажиллагчид 13.8 хувиар, бага боловсролтой ажиллагчид 11.4 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 3.3. АЖИЛЛАГЧИД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Дээд	29.2	23.5	36.0	39.2	30.9	48.5
Тусгай мэргэжлийн дунд	7.4	5.7	9.4	5.1	4.9	5.2
Техникийн болон мэргэжлийн	3.6	3.8	3.4	4.9	5.6	4.3
Бүрэн дунд	31.4	32.9	29.6	28.5	31.6	24.9
Суурь	16.2	19.0	12.9	14.9	17.7	11.8
Бага	8.7	10.6	6.3	6.0	7.6	4.3
Боловсролгүй	3.5	4.5	2.4	1.4	1.7	1.0

Дээд боловсролтой ажиллагчдад эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байгаа бол бусад боловсролын түвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.3. АЖИЛЛАГЧИД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020





АЖИЛЛАГЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Ажиллагчдын гэрлэлтийн байдлаар харвал 21.7 хувь нь огт гэрлээгүй, 73.4 хувь нь гэрлэлтээ батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй, 2.3 хувь нь гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан, 2.6 хувь нь бэлэвсэн байна.

ХҮСНЭГТ 3.4. АЖИЛЛАГЧИД, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Гэрлэлтийн байдал	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэрлээгүй	19.7	22.3	16.5	21.7	24.4	18.5
Гэрлэсэн*	74.3	74.3	74.2	73.4	73.1	73.8
Цуцалсан**	3.4	2.4	4.7	2.3	1.6	3.1
Бэлэвсэн	2.6	1.0	4.6	2.6	0.9	4.6

Тайлбар: * - Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүнийг оруулсан.

** - Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан хүнийг оруулсан.


Ажиллагчдын гэрлэлтийн байдлыг 2010 онтой харьцуулбал огт гэрлээгүй ажиллагчид 39.3 хувиар, гэрлэлтээ батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй ажиллагчид 25.2 хувиар, бэлэвсэн ажиллагчид 26.4 хувиар өссөн бол гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан ажиллагчид 14.6 хувиар буурсан байна. Бэлэвсэн ажиллагчдын хувьд гарсан өөрчлөлтийн ихэнх нь буюу 91.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол бусад гэрлэлтийн байдлаарх өөрчлөлтөд хүйсийн ялгаа байхгүй байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2010 онд 108.1 мянга байсан бол 2020 онд 106.4 мянга болж 1.6 хувиар буурсан байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт 2010 онд 19.7 мянга (18.2%) байсан бол 2020 онд 11.4 мянга (11.0 пункт)-н хүнээр нэмэгдэж 31.1 мянга (29.2%)-д хүрсэн байна. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 19.0 мянга (61.1%) нь эрэгтэйчүүд, 12.1 мянга (38.9%) нь эмэгтэйчүүд байна.




ЗУРАГ 3.4. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН



Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 23.3 хувь нь хөдөлгөөний, 15.4 хувь нь харааны, 12.4 хувь нь сэтгэцийн, 10.5 хувь нь сонсголын бэрхшээлтэй байгаа нь их хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.5. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ихэнх нь буюу 17.1 хувь нь 50-54 насныхан, хамгийн бага нь буюу 0.6 хувь 15-19 насныхан байгаа бөгөөд 15-аас 54 насанд тасралтгүй өсөж, 55, түүнээс дээш насны бүлэгт эрс буурсан байна. Энэ хандлага хот, хөдөөд хадгалагдаж байгаа ба бүх насны бүлэгт хөдөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт их байна.




ХҮСНЭГТ 3.5. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хот	Хөдөө	Дүнд эзлэх хувь		
				Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	31 092	13 298	17 794	100.0	100.0	100.0
15-19	196	54	142	0.6	0.4	0.8
20-24	1 112	442	670	3.6	3.3	3.8
25-29	2 362	1 164	1 198	7.6	8.8	6.7
30-34	3 320	1 605	1 715	10.7	12.1	9.6
35-39	4 123	1 764	2 359	13.3	13.3	13.3
40-44	4 577	1 879	2 698	14.7	14.1	15.2
45-49	5 226	2 161	3 065	16.8	16.2	17.2
50-54	5 317	2 315	3 002	17.1	17.4	16.9
55-59	3 525	1 504	2 021	11.3	11.3	11.3
60+	1 334	410	924	4.3	3.1	5.2

АЖИЛЛАГЧДЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДАЛ

Ажиллагчдын 3.9 хувь нь сүүлийн 5 жилд, 0.1 хувь нь сүүлийн 1 жилд дотоод шилжих хөдөлгөөнд орсон байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд орсон ажиллагчдын 44.8 хувь нь эрэгтэйчүүд, 55.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол сүүлийн 1 жилийн хугацаанд оролцогчдын 45.3 хувь нь эрэгтэйчүүд, 54.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3.6. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



АЖИЛЛАГЧИД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР

Ажиллагчдын 647.3 мянга (55.4%) нь үйлчилгээний, 286.3 мянга (24.5%) нь хөдөө аж ахуйн, 234.3 мянга (20.1%) нь аж үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.



Сүүлийн 10 жилд хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид 45.3 мянга (18.8%), аж үйлдвэрийн салбарт ажиллагчид 42.8 мянга (22.3%), үйлчилгээний салбарт ажиллагчид 168.3 мянга (35.1%)-аар өсжээ.

ЗУРАГ 3.7. АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН САЛБАРААР, 2010, 2020 ОН



Ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр нь ялгаж, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо болон бусад судалгаа шинжилгээнд ашигладаг.

Ажиллагчдын 24.5 хувь (эрэгтэйчүүдийн 27.4%, эмэгтэйчүүдийн 21.3%) нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр түвшинд хэвээр байна. Харин аж үйлдвэрийн салбарт эрэгтэйчүүдийн 25.1 хувь, эмэгтэйчүүдийн 14.4 хувь нь, үйлчилгээний салбарт эрэгтэйчүүдийн 47.5 хувь, эмэгтэйчүүдийн 64.3 хувь нь ажиллаж байна.

ХҮСНЭГТ 3.6. АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Салбар	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Дүнд эзлэх хувь		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 167 921	617 419	550 502	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	286 286	169 130	117 156	24.5	27.4	21.3
Уул уурхай, олборлолт	51 262	41 007	10 255	4.4	6.6	1.9
Боловсруулах үйлдвэрлэл	90 483	45 807	44 676	7.7	7.4	8.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	16 564	12 088	4 476	1.4	2.0	0.8
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 863	4 425	3 438	0.7	0.7	0.6
Барилга	68 100	51 751	16 349	5.8	8.4	3.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар, үйлчилгээ	142 180	67 986	74 194	12.2	11.0	13.4



Тээвэр агуулахын үйл ажиллагаа	58 072	45 413	12 659	5.0	7.4	2.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	27 129	7 871	19 258	2.3	1.3	3.5
Мэдээлэл холбоо	17 745	9 425	8 320	1.5	1.5	1.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	30 980	10 995	19 985	2.7	1.8	3.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4 534	2 156	2 378	0.4	0.4	0.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22 794	11 328	11 466	2.0	1.8	2.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24 730	15 433	9 297	2.1	2.5	1.7
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	94 164	57 160	37 004	8.1	9.3	6.7
Боловсрол	115 116	27 117	87 999	9.9	4.4	16.0
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	50 657	9 445	41 212	4.3	1.5	7.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10 453	5 156	5 297	0.9	0.8	1.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44 909	21 741	23 168	3.8	3.5	4.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээ	2 149	1 178	971	0.2	0.2	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1 751	807	944	0.1	0.1	0.2

Ажиллагчдыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолтын, тээвэр агуулахын, барилгын болон цахилгаан, хий, уур агааржуулалтын салбарт ажиллагчдын 73.0-80.0 хувь нь эрэгтэйчүүд байхад хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагааны, боловсролын болон зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын 71.0-81.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 3.7. АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Салбар	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Дүнд эзлэх хувь	
				Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 167 921	617 419	550 502	52.9	47.1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	286 286	169 130	117 156	59.1	40.9
Уул уурхай, олборлолт	51 262	41 007	10 255	80.0	20.0
Боловсруулах үйлдвэрлэл	90 483	45 807	44 676	50.6	49.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	16 564	12 088	4 476	73.0	27.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 863	4 425	3 438	56.3	43.7
Барилга	68 100	51 751	16 349	76.0	24.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар, үйлчилгээ	142 180	67 986	74 194	47.8	52.2
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	58 072	45 413	12 659	78.2	21.8



Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	27 129	7 871	19 258	29.0	71.0
Мэдээлэл холбоо	17 745	9 425	8 320	53.1	46.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	30 980	10 995	19 985	35.5	64.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4 534	2 156	2 378	47.6	52.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22 794	11 328	11 466	49.7	50.3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24 730	15 433	9 297	62.4	37.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	94 164	57 160	37 004	60.7	39.3
Боловсрол	115 116	27 117	87 999	23.6	76.4
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	50 657	9 445	41 212	18.6	81.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10 453	5 156	5 297	49.3	50.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44 909	21 741	23 168	48.4	51.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээ	2 149	1 178	971	54.8	45.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1 751	807	944	46.1	53.9

Сүүлийн 10 жилд уул уурхайн салбарын ажиллагчдад хөдөөгийн ажиллагчдын эзлэх хувийн жин 6.2 пунктээр буурсан бол боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдынх 9.7 пунктээр өссөн байна. Мөн хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээний үйл ажиллагааны салбарын ажиллагчдад хөдөөгийн ажиллагчдын эзлэх хувийн жин 13.6 пунктээр өссөн байна.

Хот, суурин газарт бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний, боловсролын, боловсруулах үйлдвэрлэлийн, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт ажиллагчдын хувийн жин өндөр байна. Гэхдээ хот, суурин газарт хөдөөгийнх шиг нэг салбарт хэт төвлөрсөн бус харьцангуй жигд тархсан байна. Хөдөөд амьдарч буй 5 ажиллагч тутмын 3 нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилтын салбарт ажиллаж байна.

ХҮСНЭГТ 3.8. АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, БАЙРШЛААР, 2020 ОН


Салбар	Бүгд	Хот	Хөдөө	Дүнд эзлэх хувь	
				Хот	Хөдөө
БҮГД	1 167 921	740 007	427 914	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	286 286	28 331	257 955	3.8	60.3
Уул уурхай, олборлолт	51 262	37 668	13 594	5.1	3.2
Боловсруулах үйлдвэрлэл	90 483	73 571	16 912	9.9	4.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	16 564	13 658	2 906	1.9	0.7
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 863	6821	1 042	0.9	0.2
Барилга	68 100	58 958	9 142	8.0	2.1



Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар, үйлчилгээ	142 180	123 037	19 143	16.6	4.5
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	58 072	49 973	8 099	6.8	1.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	27 129	22 674	4 455	3.1	1.0
Мэдээлэл холбоо	17 745	15 907	1 838	2.1	0.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	30 980	25 921	5 059	3.5	1.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4 534	4 210	324	0.6	0.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22 794	19 131	3 663	2.6	0.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24 730	21 407	3 323	2.9	0.8
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	94 164	69 824	24 340	9.4	5.7
Боловсрол	115 116	80 329	34 787	10.9	8.1
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	50 657	38 947	11 710	5.3	2.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10 453	7 725	2 728	1.0	0.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44 909	38 613	6 296	5.2	1.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээ	2 149	1 703	446	0.2	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1 751	1 599	152	0.2	0.0

Боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа 15-24 насны залуучуудын 58.9 хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байна. Насны бүлэг тус бүрийн хувьд, нас ахих тусам үйлчилгээний салбарт ажиллагчдын эзлэх хувийн жин аажмаар буурч хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид ихсэж байна. Харин аж үйлдвэрийн салбарын хувьд, 15-54 насны таван хүн тутмын нэг нь уг салбарт ажиллаж байхад 55-64 насныхны 15.7 хувь, 65 ба түүнээс дээш насныхны 7.9 хувь нь ажиллаж байна.

ЗУРАГ 3.8. АЖИЛЛАГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН САЛБАРААР, 2020 ОН





АЖИЛ МЭРГЭЖИЛ

Ажиллагчдыг эрхэлж буй үйл ажиллагааных нь ажил мэргэжлээр авч үзэхэд, ихэнх нь буюу 23.9 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн, 19.8 хувь нь мэргэжилтний, 12.0 хувь нь худалдаа, үйлчилгээний, 10.1 хувь нь менежерийн ажил мэргэжлээр ажиллаж байна. Хүйсийн хувьд, эрэгтэйчүүдийн ихэнх нь буюу 26.9 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн, 13.9 хувь нь машин механизм, төхөөргийн операторч, угсрагчийн, 13.5 хувь нь мэргэжилтний ажил мэргэжлээр ажиллаж байхад эмэгтэйчүүдийн 27.0 хувь нь мэргэжилтэн, 20.7 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтны, 16.3 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтны ажил мэргэжлээр ажиллаж байна.

ХҮСНЭГТ 3.9. АЖИЛЛАГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Дүнд эзлэх хувь		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 167 921	617 419	550 502	100.0	100.0	100.0
Менежер	117 610	59 790	57 820	10.1	9.7	10.5
Мэргэжилтэн	231 682	83 166	148 516	19.8	13.5	27.0
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	49 472	24 952	24 520	4.2	4.0	4.5
Контор, үйлчилгээний ажилтан	42 814	13 630	29 184	3.7	2.2	5.3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	139 715	50 140	89 575	12.0	8.1	16.3
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	279 610	165 779	113 831	23.9	26.9	20.7
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	89 475	62 888	26 587	7.7	10.2	4.8
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	94 471	85 656	8 815	8.1	13.9	1.6
Энгийн ажил, мэргэжил	100 522	52 340	48 182	8.6	8.5	8.8
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	22 550	19 078	3 472	1.9	3.1	0.6

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУС

Хөдөлмөр эрхлэлтийн статусыг 2018 онд болсон Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 20-р бага хурлаар шинэчлэн баталсан ба хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогод уг шинэчилсэн хөдөлмөр эрхлэлтийн статусыг ашигласан болно. 2010 болон 2020 оны тооллогын хөдөлмөр эрхлэлтийн хоёр өөр статусыг ашигласан учир дараах байдлаар харьцуулсан болно.



ЗУРАГ 3.9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЧИН БОЛОН ШИНЭ СТАТУСЫН ХАРЬЦУУЛАЛТ



Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн статус сүүлийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. 2020 онд цалин хөлстэй ажиллагч нийт ажиллагчдын 67.0 хувийг эзэлж 2010 оныхоос 10.8 пунктээр өсжээ. Харин ажил олгогчийн эзлэх хувь 0.6 хувь болж 2010 оныхоос 1.9 пунктээр, хувиараа хөдөлмөр эрхлэгчид (нөхөрлөл хоршооны гишүүд болон гүйцэтгэгч гэрээлэгчийг оруулсан)-ийн хувь 26.5 болж 1.4 пунктээр тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 3.10. АЖИЛЛАГЧИД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУС, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Хөдөлмөр эрхлэлтийн статус	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010			
БҮГД	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй ажиллагч	56.2	53.6	59.3
Ажил олгогч	2.5	3.1	1.8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	27.7	37.7	15.9
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	0.2	0.2	0.2
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	12.9	4.9	22.5
Бусад	0.5	0.5	0.3



2020

БҮГД	100.0	100.0	100.0
Ажил олгогч	0.6	0.7	0.5
Ажилтан ажиллуулдаггүй хувиараа хөдөлмөр эрхлэгч	26.1	32.6	18.8
Цалин хөлстэй ажиллагч	67.0	63.5	70.9
Гүйцэтгэх гэрээлэгч	0.4	0.7	0.2
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	5.9	2.5	9.6

Ажил олгогч болон ажилтан ажиллуулдаггүй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дотор нь үйл ажиллагааны нэгжийнх нь хувьд, цалин хөстэй ажиллагчдыг гэрээ, гэрээний хугацаагаар нь дэд ангилал үүсгэн дараах хүснэгтээр харууллаа. Улсын хэмжээнд нийт ажиллагчдын 782.2 мянга (67.0%) нь цалин хөлстэй ажиллагчид байгаагийн 695.5 мянга (88.9%) нь байнгын ажиллагчид, 75.2 мянга (9.6%) нь түр ажиллагчид, 11.1 мянга нь (1.4%) нь тохиолдлын ажиллагчид байна.

ХҮСНЭГТ 3.1. АЖИЛЛАГЧИД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУС, ХҮЙС, БАЙРШЛААР, 2020 ОН

Хөдөлмөр эрхлэлтийн статус	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хот	Хөдөө
БҮГД	1 167 921	617 419	550 502	740 007	427 914
Ажил олгогч	7 249	4 522	2 727	6 183	1 066
ААНБ-ын	4 879	3 197	1 682	4 316	563
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн	2 370	1 325	1 045	1 867	503
Ажилтан ажиллуулдаггүй хувиараа хөдөлмөр эрхлэгч	304 521	200 896	103 625	94 912	209 609
ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	3 609	1 796	1 813	2 300	1 309
Өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	300 912	199 100	101 812	92 612	208 300
Цалин хөлстэй ажиллагч	782 212	392 188	390 024	627 471	154 741
Байнгын ажиллагч	695 534	341 236	354 298	555 216	140 318
Түр ажиллагч	75 243	43 108	32 135	62 513	12 730
Тохиолдлын ажиллагч	11 073	7 642	3 431	9 508	1 565
Дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	362	202	160	234	128
Гүйцэтгэх гэрээлэгч	5 337	4 168	1 169	4 178	1 159
Гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагч	68 602	15 645	52 957	7 263	61 339

Харин ажил олгогчдын 67.3 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 32.7 хувь нь зэх зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч байхад ажилтан ажиллуулдаггүй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 98.8 хувь нь өрхийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгч, 1.2 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч байна.

Гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагчдын 77.2 хувь, цалин хөлстэй байнгын ажиллагчдын 50.9 хувь, ажилтан ажиллуулдаггүй аж ахуйн нэгж




байгууллагын үйл ажиллагаа эрхлэгчдийн 50.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол бусад статусын хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 5.7-56.2 пунктээр их байна. Хүйсийн хувьд хамгийн их зөрүүтэй байгаа нь гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагчид, хамгийн бага зөрүүтэй нь ажилтан ажиллуулдаггүй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа эрхлэгчид байна.

Байршлын хувьд авч үзэхэд, гэр бүлийн гишүүдэд хувь нэмэр оруулагчдын 89.4 хувь, ажилтан ажиллуулдаггүй өрхийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгчдийн 69.2 хувь нь хөдөө амьдарч байна. Үүнд нийт ажиллагчдын 24.5 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, тэдгээрийн 60.9 хувь нь хөдөө амьдарч байгаа нь нөлөөлсөн ба манай улсын нүүдлийн соёл иргэншил бүхий мал аж ахуй эрхлэлтийн илэрхийлэл.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН

Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.8 хувь, эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс 9.5 пунктээр бага байна. Харин байршлын хувьд хот, суурин газарт хөдөө, орон нутгийнхаас 10.1 пунктээр доогуур (эрэгтэйчүүдийнх 11.8 пунктээр, эмэгтэйчүүдийнх 7.8 пунктээр) байна.

ЗУРАГ 3.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, 2020 ОН




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛГЭЭР

Хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг насны бүлгээр нь авч үзэхэд, 15-19 насны бүлэгт хамгийн бага буюу 7.3 хувь, 40-44 насанд хамгийн их буюу 73.0 хувь байна. Харин насны бүлэг дэх хүйсийн ялгааг авч үзэхэд 45-49 насны бүлэгт хүйсийн ялгаа байхгүй буюу аль аль нь 71.9 хувьтай, 40-44 насны бүлэгт харьцангуй ойролцоо буюу эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 1.6 пунктээр их байхад, хамгийн их зөрүүтэй нь 55-59 насанд 25.5 пунктээр, 60-64 насанд 17.5 пунктээр, 20-24 насанд 12.9 пунктээр эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс их байна.




ЗУРАГ 3.2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН ХҮЙС, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН



Хот, хөдөөгийн ялгаатай байдлаар болон насны бүлгээр авч үзэхэд, бүх насны бүлэгт хөдөөд хөдөлмөр эрхлэлтийн түвшин хот, суурин газрынхаас их байгаа бөгөөд 60-64 насны бүлэгт 20.5 пунктээр, 55-59 насны бүлэгт 19.3 пунктээр их байгаа нь хамгийн их зөрүүтэй байгаа бол 15-19 насанд 4.4 пунктээр, 20-24 насанд 7.2 пунктээр, 25-29 насанд 8.8 пунктээр их буюу зөрүүтэй бага байна.

ЗУРАГ 3.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР

Боловсролын түвшнээр авч үзэхэд, дээд боловсролтой ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшин хамгийн өндөр буюу 70.4 хувь байна. Энэ нь хүйсийн хувьд ч хадгалагдсан (эрэгтэй 73.3 хувь, эмэгтэй 68.4 хувь) байна. Хүйсээр ялгаатай байдлыг авч үзэхэд, бүх түвшинд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эмэгтэйчүүдийнхээс их байгаа бөгөөд уг ялгаа бага боловсролын түвшинд хамгийн их (25.8 пункт), дээд боловсролын түвшинд хамгийн бага (5.0 пункт) зөрүүтэй байна.




ЗУРАГ 3.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2020 ОН



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР

Хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг гэрлэлтийн байдлаас хэрхэн хамаарч байгааг дараах зургаар харууллаа. Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 6.9 пунктээр их байхад бусад гэрлэлтийн байдлын хувьд эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс 2.6-9.9 пунктээр их байна.

ЗУРАГ 3.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2020 ОН




Тайлбар: * - Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүнийг оруулсан.
 ** - Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан хүнийг оруулсан.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР

Сүүлийн 1 жилд шилжих хөдөлгөөнд орсон хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин сүүлийн 5 жилийнхтэй харьцуулахад бага (4.4 пунктээр) байна. Мөн сүүлийн 5 жилийн хугацаад шилжих хөдөлгөөнд ороогүй эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин шилжих хөдөлгөөнд орсон эрэгтэйчүүдийнхээс 1.7 пунктээр бага байгаа бол бусад аль ч хугацаа, хүйсийн хувьд шилжих хөдөлгөөнд ороогүй хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр байна.

ЗУРАГ 3.6. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2020 ОН



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ДЭХ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт дэх тэгш байдлыг хэмжих нэг үзүүлэлт бол Тогтвортой хөгжлийн зорилтын 5 дугаар Зорилгын үзүүлэлт болох “5.5.2. Удирдах албан тушаалд ажиллагчдад эмэгтэйчүүдийн эзлэх хувь” шалгуур үзүүлэлт юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор улсын хэмжээнд удирдах албан тушаалд 105.5 мянган хүн ажиллаж байгаагийн 50.9 мянга буюу 48.2 хувь нь эмэгтэйчүүд байна.


Мөн хөдөө аж ахуйн бус салбар дахь цалин хөлстэй ажиллагчдын эзлэх хувийн жин нь хөдөлмөр эрхлэх боломж хэр байгаа талаарх мэдээллийг өгдөг. Учир нь хөдөө аж ахуйн бус салбарт цалин хөлстэй ажиллагчид нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хөдөө аж ахуйн салбарт ажиллагчидтай харьцуулахад эдийн засгийн эрсдэлд өртөх нь бага байх талтай. Гэхдээ энэ байдал нь үндсэндээ байнгын ажиллагчдад хамааралтай.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор улсын хэмжээнд хөдөө аж ахуйн бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдэд байнгын цалин хөлстэй ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 82.1 хувьтай (эрэгтэйчүүдийнхээс 5.4



пунктээр их) байна. Харин байршлаар авч үзэхэд, хөдөө 80.6 хувь, хот, суурин газарт 80.3 хувьтай байна.

ЗУРАГ 3.7. ХӨДӨӨ АЖ АХУЙН БУС САЛБАРТ АЖИЛЛАГЧДАД БАЙНГЫН ЦАЛИН ХӨЛСТЭЙ АЖИЛЛАГЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, БАЙРШЛААР, 2020 ОН



Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг ажил, мэргэжлийн хүрээнд тэнцвэргүй хуваарилахыг жендэрийн ялгарал гэнэ. Ажил мэргэжлийн хоёр төрлийн жендэрийн ялгарал бий. Эхнийх нь вертикал буюу босоо ялгарал, энэ нь албан тушаалын дээд хэсэгт эрэгтэйчүүд олноороо, харин доод хэсэгт эмэгтэйчүүд олноороо байхыг хэлж байна. Хоёрдахь хэлбэр нь горизонтал буюу хөндлөн ялгарал, энэ нь нэг ажил, мэргэжлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг өөр өөр байхыг (нэг мэргэжил дотроо ялгарах) хэлэх бөгөөд нарийвчилсан судалгаагаар судлах боломжтой.

Менежерийн болон техникч болон туслах, дэд мэргэжилтний ажил мэргэжлээр ажиллаж байгаа ажиллагчдын хүйсээрх ялгаа харьцангуй бага байна. Харин мэргэжилтэн, контор, үйлчилгээний, худалдаа үйлчилгээний ажил мэргэжлээр ажиллаж байгаа ажиллагчдын 64.1-68.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол машин механизм, төхөөргийн операторч, угсрагч, зэвсэгт хүчний ажил мэргэжлээр ажиллаж байгаа ажиллагчдын 84.6-90.7 хувь нь эрэгтэйчүүд байна.

Хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн эрх тэгш байдлыг дээрх үзүүлэлтээр илэрхийлэхээс гадна учир шалтгааныг тодруулах тусгайлсан судалгаа, шинжилгээ хийх нь зохимжтой. Мөн хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн эрх тэгш байдлыг жендэрт суурилсан цалингийн ялгаа бүхий үзүүлэлтээр илэрхийлэх бөгөөд энэ талаарх тоо мэдээллийг Ажиллах хүчний судалгааны эх үүсвэрээс авч тооцох боломжтой.



ЗУРАГ 3.8. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЯЛГАРАЛ, ХҮЙСЭЭР, 2020 ОН





ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АЖИЛГҮЙДЭЛ



АЖИЛГҮЙ ИРГЭД, ТЭДГЭЭРИЙН БҮТЭЦ

Улсын хэмжээнд ажиллах хүчний 128.8 мянга (9.9%) нь ажилгүй иргэд байгаагийн 68.7 мянга (53.3%) эрэгтэйчүүд, 60.1 мянга (46.7%) нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй иргэд 2010 онтой харьцуулахад 35.3 мянгаар (21.5%), хүйсийн хувьд эрэгтэйчүүд 26.3 мянга (27.7%), эмэгтэйчүүд 9.0 мянгаар (13.0%) буурсан байна.

ХҮСНЭГТ 4.1. АЖИЛГҮЙ ИРГЭД, БҮС, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

	2010						2020					
	Бүгд		Хүйсээр				Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй				Эрэгтэй		Эмэгтэй	
мян. хүн	%	мян. хүн	%	мян. хүн	%	мян. хүн	%	мян. хүн	%	мян. хүн	%	
БҮГД	164.0	100.0	95.0	100.0	69.0	100.0	128.8	100.0	68.7	100.0	60.1	100.0
Хот	114.5	69.8	65.9	69.4	48.6	70.4	112.4	87.3	59.5	86.6	52.9	88.0
Хөдөө	49.5	30.2	29.1	30.6	20.4	29.6	16.4	12.7	9.2	13.4	7.2	12.0
БҮС												
Баруун	30.2	18.4	17.6	18.5	12.6	18.3	11.3	8.8	5.7	8.3	5.6	9.3
Хангай	13.7	8.3	7.8	8.2	5.9	8.6	12.0	9.3	6.5	9.5	5.5	9.2
Төв	23.2	14.1	13.2	13.9	10.0	14.5	9.9	7.7	5.6	8.2	4.3	7.2
Зүүн	36.3	22.1	20.7	21.8	15.6	22.6	10.5	8.2	5.3	7.7	5.2	8.7
Улаан-баатар	60.7	37.0	35.7	37.6	25.0	36.2	85.2	66.1	45.7	66.5	39.5	65.7

Ажилгүй иргэд 112.4 мянга (87.3%) нь хот суурин газар, 16.4 мянга (12.7%) нь хөдөө орон нутагт оршин суугаа бөгөөд нийт ажилгүй иргэдийн 85.2 мянга (66.1%) нь Улаанбаатар хотод, 12.0 мянга (9.3%) нь Хангайн бүсэд, 11.3 мянга (8.8%) нь Баруун бүсэд, 10.5 мянга (8.2%) нь Зүүн бүсэд, 9.9 мянга (7.7%) нь Төвийн бүсэд амьдарч байна. Улсын хэмжээнд ажилгүй иргэд 2010 оноос буурахад Зүүн бүсэд ажилгүй иргэд 25.8 мянгаар (71.1%), Баруун бүсэд 18.9 мянгаар (62.7%), Төвийн бүсэд 13.3 мянгаар (57.4%), Хангайн бүсэд 1.7 мянгаар (12.2%) буурсан нь нөлөөлсөн ч Улаанбаатар хотод ажилгүй иргэд 2010 онтой харьцуулахад 24.5 мянга (40.3%-аар өссөн байна.

АЖИЛГҮЙ ИРГЭД, НАСНЫ БҮЛГЭЭР

Ажилгүй иргэд 2010 онтой харьцуулахад буурсан ч, насны бүлгээр авч үзэхэд сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна. Нийт ажилгүй хүнд 15-29 насныхны эзлэх хувь 2010 онтой харьцуулахад буурч, бусад насны бүлэгт өссөн байна. Тухайлбал, 20-24 насны бүлэгт 18.5 пункт, 15-19 насны бүлэгт 6.4 пункт, 25-29 насны бүлэгт 5.8 пунктээр буурсан бол хамгийн их өсөлттэй байгаа нь 50-54 насны бүлэгт 7.6 пункт, 55-59 насны бүлэгт 7.3 пункт, 45-49 насны бүлэгт 5.9 пункт, 40-44 насны бүлэгт 4.0 пунктээр тус тус өссөн байна.

Нийт ажилгүй хүний хамгийн их хувийг 30-34 насныхан (18.7%) эзэлж, насны бүлэг ахих тусам тухайн насны бүлгийн эзлэх хувийн жин аажмаар буурч байгаа бөгөөд хүйсийн хувьд энэ хандлага хадгалагдаж байна.




ХҮСНЭГТ 4.2. АЖИЛГҮЙ ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-19	7.0	7.6	6.2	0.6	0.7	0.5
20-24	23.4	22.8	24.2	4.9	4.9	4.8
25-29	18.7	18.0	19.8	12.9	12.7	13.1
30-34	15.8	15.5	16.2	18.7	19.2	18.1
35-39	13.4	13.4	13.4	15.8	16.3	15.2
40-44	10.6	10.4	10.8	14.6	15.2	13.9
45-49	7.3	7.4	7.1	13.2	13.0	13.5
50-54	3.1	3.8	2.1	10.7	9.7	11.7
55-59	0.7	1.1	0.2	8.0	7.4	8.8
60+	0.0	0.0	0.0	0.6	0.9	0.4

Харин насны бүлэг дэх хүйсийн харьцааг авч үзэхэд, 50-59 насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.2-2.6 пунктээр их байгаа бол бусад насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 4.8-46.4 пунктээр их байна. Мөн насны бүлэг дэх хүйсийн харьцаа хамгийн их зөрүүтэй байгаа нь 60, түүнээс дээш насанд 46.4 пунктээр, хамгийн бага нь 55-59 насны бүлэгт 2.2 пунктээр зөрүүтэй байна.

ЗУРАГ 4.1. АЖИЛГҮЙ ИРГЭД, ХҮЙС, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Улсын хэмжээнд нийт ажилгүй иргэийн 99.0 хувь нь боловсролтой, үүнээс эрэгтэйчүүдийн 98.9 хувь, эмэгтэйчүүдийн 99.3 хувь нь ямар нэг түвшний боловсрол эзэмшжээ. Тухайлбал, нийт ажилгүй иргэдийн 43.9 хувь нь бүрэн дунд, 31.5 хувь нь дээд боловсролтой байгаа бөгөөд хүйсийн хувьд уг хандлага хадгалагдсан байна.




2010 онтой харьцуулахад дээд боловсролтой ажилгүй иргэд 42.7 хувиар өссөн бол боловсролгүй нь 77.4 хувиар, бага боловсролтой нь 71.9 хувиар, суурь боловсролтой нь 53.0 хувиар, тусгай мэргэжлийн дунд нь 24.1 хувиар, техникийн болон мэргэжлийн боловсролтой нь 23.7 хувиар, бүрэн дунд боловсролтой нь 18.6 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 4.3. АЖИЛГҮЙ ИРГЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Дээд	17.3	12.0	24.7	31.5	25.7	38.0
Тусгай мэргэжлийн дунд	4.8	4.2	5.6	4.6	4.2	5.1
Техникийн болон мэргэжлийн	4.3	4.2	4.3	4.1	4.4	3.9
Бүрэн дунд	42.4	42.9	41.7	43.9	47.0	40.5
Суурь	20.3	23.3	16.1	12.2	14.2	9.8
Бага	7.6	9.3	5.3	2.7	3.4	2.0
Боловсролгүй	3.3	4.1	2.3	1.0	1.1	0.7

Дээд болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажилгүй иргэдэдэмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдээс 2.7-12.8 пунктээр их байгаа бол бусад түвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 13.3-27.3 пунктээр их байна. Боловсролын түвшин дэх хүйсийн ялгаатай байдал тусгай мэргэжлийн дунд түвшинд хамгийн бага буюу 2.7 пункт, бага боловсролын түвшинд хамгийн их буюу 30.9 пунктын зөрүүтэй байна.

ЗУРАГ 4.2. АЖИЛГҮЙ ИРГЭД, ХҮЙС, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ДЭХ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН






ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 32.8 мянга (33.4%) нь ажиллах хүч байгаагийн 1.7 мянга (5.4%) нь ажилгүй иргэд, тэдгээрийн 1.0 мянга (57.0%) нь эрэгтэйчүүд, 0.7 мянга (43.0%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 4.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН




Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзэхэд, 20.0 хувь нь хөдөлгөөний, 15.7 хувь нь харааны, 14.7 хувь нь сэтгэцийн, 9.7 хувь нь сонсголын бэрхшээлтэй байгаа нь их хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүй иргэдийн хамгийн их хувийг 50-54 насныхан (15.7%), хамгийн бага нь буюу 0.3 хувь нь 65-69 насныхан байна.

ЗУРАГ 4.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН





ЗУРАГ 4.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ХҮЙС, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН



АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр ажилгүйдлийн түвшин 9.9 хувьд хүрч, 2010 оноос 5.4 пунктээр буурсан бол хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх 6.1 пунктээр, эмэгтэйчүүдийнх 4.4 пунктээр буурсан байна.

Хот суурин газарт 2010 онд ажилгүйдлийн түвшин хөдөөгийнхөөс 3.5 пунктээр их байсан бол энэ зөрүү 2020 онд ихсэж 9.5 пункт болсон байна. Энэ нь хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин өмнөх тооллогын үеэс 9.2 пунктээр буурсантай холбоотой.

ХҮСНЭГТ 4.4. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, БҮС, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	15.3	16.1	14.2	9.9	10.0	9.8
Хот	16.5	17.8	15.2	13.2	13.6	12.8
Хөдөө	13.0	13.2	12.4	3.7	3.7	3.7
БҮС						
Баруун	17.3	17.8	16.8	7.4	6.8	8.0
Хангайн	16.5	17.4	15.4	4.7	4.7	4.6
Төв	15.6	15.9	15.3	4.7	4.8	4.6
Зүүн	18.0	18.4	17.5	11.4	10.5	12.4
Улаанбаатар	13.4	14.7	12.0	14.5	15.2	13.8

Ажилгүйдлийн түвшнийг 2010 онтой харьцуулахад 15-44 насны бүлэгт 1.9-26.5 пунктээр буурч, 45 ба түүнээс дээш насны бүлэгт 0.5-9.3 пунктээр өссөн байна. 2020 оны байдлаар 15-29 насны бүлэг болон 60, түүнээс дээш насанд ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 1.1-7.8 пунктээр бага, 30-59 насны бүлэгт 0.5-3.9 пунктээр их




байна. Уг хандлага эрэгтэйчүүдийн хувьд хадгалагдаж байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд 15-29, 40-44 насны бүлэг болон 60, түүнээс дээш насанд нийт эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшнээс 0.2-8.3 пунктээр бага, 35-39 насны бүлэгт тэнцүү, бусад насны бүлэгт 0.2-6.9 пунктээр их байна.

ХҮСНЭГТ 4.5. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010					2020				
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хот	Хөдөө	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хот	Хөдөө
БҮГД	15.3	16.1	14.2	16.5	13.0	9.9	10.0	9.8	13.2	3.7
15-19	31.0	27.8	38.2	39.5	22.9	4.5	3.8	6.3	5.5	3.6
20-24	23.8	22.9	25.0	24.8	21.8	6.3	5.9	6.9	7.1	5.2
25-29	16.5	16.6	16.5	17.5	14.6	8.8	8.6	9.0	10.4	5.3
30-34	15.2	16.0	14.3	16.5	12.8	10.4	10.8	10.0	12.8	4.3
35-39	14.0	15.5	12.3	15.2	11.7	10.5	11.1	9.8	13.8	3.4
40-44	12.5	14.1	10.9	13.6	10.6	10.7	11.8	9.6	14.7	3.0
45-49	10.4	12.3	8.6	11.3	8.7	11.0	11.7	10.2	15.3	3.1
50-54	7.1	9.4	4.4	8.1	5.3	11.3	11.3	11.4	15.9	3.1
55-59	4.5	6.0	1.2	5.8	2.5	13.8	11.7	16.7	20.1	2.6
60+	0.5	0.5	0.4	0.7	0.2	2.1	2.5	1.5	3.3	1.0

Ажилгүйдлийн түвшнийг гэрлэлтийн байдлаар авч үзвэл, гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан хүмүүсийн ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хүйсийн хувьд ч мөн хамгийн их нь байна. Хүйсээр авч үзвэл гэр бүлтэй эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин ойролцоо түвшинд байгаа бол огт гэр бүл болоогүй, гэрлэж байсан эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин нь тухайн бүлгийн эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшнээс 0.9-5.1 пунктээр их байна. Энэ нь залуучуудын дунд эмэгтэйчүүд боловсрол, сургалтад хамрагдах нь их, нөгөөтээгүүр эмэгтэйчүүд өрх толгойлсон тохиолдолд үр хүүхдээ тэжээх ачаалал үүрч эхэлдэгтэй холбоотой байх талтай.

ЗУРАГ 4.6. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Тайлбар: * - Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүнийг оруулсан.
 ** - Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан хүнийг оруулсан.



Сүүлийн 1 жилийн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын ажилгүйдлийн түвшин оролцоогүй хүн амынхаас их байгаа бол сүүлийн 5 жилийн хувьд эсрэгээрээ буюу оролцсон хүн амын ажилгүйдлийн түвшин бага байна.

ЗУРАГ 4.7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДЛААР, 2020 ОН



ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЭЛ

Тухайн улс орны хөгжлийн үе шатнаас үл хамааран хөдөлмөрийн насны залуучуудын ажилгүйдэл бодлогын маш чухал асуудалд тооцогддог. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас “залуучууд” гэдэг нэр томъёонд 15-24 насны хүмүүсийг, “ерөнхий хөдөлмөрийн насанд хүрэгсэд” гэдэгт 25 ба түүнээс дээш насны хүн амыг хамруулдаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас залуучуудтай холбоотой 4 тодорхой хэмжигдэхүүнийг авч үзэхийг зөвлөмж болгодог. Үүнд:

- Залуучуудын ажилгүйдлийн түвшин (15-24 насны ажиллах хүчинд 15-24 насны ажилгүй залуучуудын эзлэх хувь);
- Залуучуудын ажилгүйдлийн болон ерөнхий хөдөлмөрийн насанд хүрэгсдийн ажилгүйдлийн харьцаа;
- Нийт ажилгүй хүнд залуучуудын эзлэх хувь;
- 15-24 насны залуучуудад ажилгүй залуучуудын эзлэх хувийн жин.

Ажилгүйдэл нь ерөнхийдөө залуу ажиллах хүчинд харьцангуй нөлөөлдөг бөгөөд 2010 онд залуучуудын ажилгүйдлийн түвшин 25.1 хувь байсан бол 2020 онд эрс буурч 6.0 хувь болсон байна.




ХҮСНЭГТ 4.6. ЗАЛУУЧУУДЫН БОЛОН НИЙТ АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШНИЙ ХАРЬЦАА, 2010, 2020 ОН

Үзүүлэлт	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Нийт ажилгүйдлийн түвшин (15+)	15.3	16.1	14.2	9.9	10.0	9.8
Залуучуудын ажилгүйдлийн түвшин (15-24)	25.1	24.0	26.9	6.0	5.5	6.8
Залуучуудын болон нийт ажилгүйдлийн түвшний харьцаа	1.6	1.5	1.9	0.6	0.6	0.7
Залуучууд болон насанд хүрэгчдийн ажилгүйдлийн харьцаа	1.9	1.7	2.3	0.6	0.5	0.7
Нийт ажилгүйчүүдэд залуучуудын эзлэх хувь	30.4	30.3	30.5	6.3	6.5	6.0
Нийт залуучуудад ажилгүй залуучуудын эзлэх хувь	9.1	10.4	7.7	1.6	1.7	1.5

Залуучуудын болон нийт ажилгүйдлийн түвшнийг харьцуулан дараах зурагт үзүүлэв. Босоо тэнхлэгт залуучуудын ажилгүйдлийн түвшин (15-24 насныхан), хэвтээ тэнхлэгт нийт хүн амын ажилгүйдлийн түвшинг (15, түүнээс дээш насны) харуулав. Саарал талбай нь залуучуудын ажилгүйдлийн түвшин нь нийт ажилгүйдлийн түвшнээс бага, цэнхэр талбай нь залуучуудын ажилгүйдлийн түвшин нь нийт ажилгүйдлийн түвшнээс их боловч 2 дахин их биш хүлээгдэж буй байдлыг, ногоон талбай нь залуучуудын ажилгүйдлийн түвшин нь нийт ажилгүйдлийн түвшнээс өндөр буюу 2-3 дахин их, улаан талбай нь залуучуудын ажилгүйдлийн түвшин нь нийт ажилгүйдлийн түвшнээс 3-аас дээш дахин их буюу тухайн улсын залуучуудын ажилгүйдэл хүнд байгааг харуулдаг.

ЗУРАГ 4.8. НИЙТ БОЛОН ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШНИЙ ХАРЬЦАА, 2010, 2020 ОН



Нийт ажилгүйдлийн түвшин болон залуучуудын ажилгүйдлийн түвшнийг харьцуулахад 2010 онд 1.6 (цэнхэр талбайд), өөрөөр хэлбэл залуучуудын



ажилгүйдлийн түвшин бага буюу ажилгүйдлийн түвшнээс 2 дахин их байсан. Харин 2020 онд 0.6 болж буурсан эерэг үзүүлэлттэй (саарал талбайд) байна.


ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ, БОЛОВСРОЛ, СУРГАЛТАД ХАМРАГДААГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУД

Залуучуудын ажилгүйдлийн түвшний үзүүлэлт нь залуучуудын хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх зарим мэдээллийг л илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл эдгээр тоо мэдээлэл нь залуучуудад тулгарч буй асуудлыг бүрэн илэрхийлж чадахгүй бөгөөд шийдвэр гаргах үйл явцад үүнээс дэлгэрэнгүй, бодитой мэдээлэл шаардлагатай. Харин хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын талаарх үзүүлэлт нь ажилгүй залуучууд гэхээсээ илүүтэйгээр хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирэх боломжтой ажиллах хүчний нөөцийн хэмжүүр болж өгдөг. Үүнд ажил хайхаас шантарсан залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй, гэр орныхоо ажилд тусалдаг гэх зэрэг бусад олон шалтгаанаар ажиллах хүчнээс гадуур байгаа залуучууд хамрагдана.

Тиймээс ч Тогтвортой хөгжлийн зорилгын “2020 он гэхэд хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах” гэж авч үзсэн бөгөөд 8.6 дугаар Зорилтын хэрэгжилтийг 8.6.1 буюу “15-24 насны хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын эзлэх хувь” гэсэн шалгуур үзүүлэлтээр тооцно. Уг үзүүлэлт нь хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучууд тухайн насны хүн амын хэдэн хувийг эзэлж буйг илэрхийлнэ.

Монгол Улсын хувьд нийт хүн амын 13.8 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 20.4 хувийг 15-24 насны залуучууд эзэлдэг. Энэ нь залуу насны бүтэцтэй, хүн ам зүйн цонх нээгдсэн манай улс орны хувьд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц нөхцөл бүрэлдсэн, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх боломжтой үе юм.

ЗУРАГ 4.9. 15-24 НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ, БОЛОВСРОЛ, СУРГАЛТАД ХАМРАГДААГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН





15-24 насны хүн амын 12.2 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй залуучууд байна. Энэ нь хөдөлмөрлөх насны залуучуудын 8 хүн тутмын 1 нь хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгааг илэрхийлж байна. Ялангуяа 15-24 насны хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй эмэгтэйчүүдийн хувь 12.5 буюу улсын дүнгээс 0.3 пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны хүн ам их байгаа хүн ам зүйн таатай нөхцөл байдал, боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байгааг цаашид анхааран судлах шаардлагатай юм.

Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын 94.7 хувь нь боловсролтой, үүнээс 24.1 хувь нь дээд боловсролтой, 11.4 хувь нь техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролтой залуучууд байна. Ялангуяа энэ насны хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй эмэгтэйчүүдийн 32.8 хувь, эрэгтэйчүүдийн 15.2 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.



ТАВДУГААР БҮЛЭГ

БҮС, ОРОН НУТГИЙН ЯЛГАА



ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН БҮТЦИЙН ЯЛГАА

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр, хүн ам харилцан адилгүйн зэрэгцээ газарзүйн хэд хэдэн бүсэд оршдог, байгалийн баялаг улс орны нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газарзүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран аймаг, нийслэлийн хүн амын суурьшил нягтрал, хөгжлийн түвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ. Хүн амын суурьшлын ерөнхий дүр төрх өмнөх тооллогоос бага зэрэг өөрчлөгдөн төв суурин газар луу чиглэсэн шилжих хөдөлгөөн ялангуяа Баруун бүсээс Төвийн бүс, Улаанбаатар хот болон нийслэлд олон мянган хүн шилжсэн нь бүс нутгийн хүн ам сийрэгжихэд нөлөөлжээ. Түүнчлэн сүүлийн 10 жилд нийслэл, аймгийн түвшинд хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо харилцан адилгүй өөрчлөгдсөн байна.

Ажиллах хүчний 45.3 хувь нь Улаанбаатар хотод, 19.7 хувь нь Хангайн бүсэд, 16.1 хувь нь Төвийн бүсэд, 11.8 хувь нь Баруун бүсэд, 7.1 хувь нь Зүүн бүсэд амьдарч байна.

ХҮСНЭГТ 5.1. АЖИЛЛАХ ХҮЧ, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Бүс, аймаг, нийслэл	2010			2020			2020 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
УЛСЫН ДҮН	1 075 780	590 132	485 648	1 296 781	686 163	610 618	120.5
БАРУУН БҮС	134 019	74 306	59 713	153 118	82 752	70 366	114.3
Баян-Өлгий	29 107	16 719	12 388	32 748	17 918	14 830	112.5
Говь-Алтай	22 701	12 400	10 301	26 046	13 664	12 382	114.7
Завхан	25 918	14 085	11 833	29 938	16 187	13 751	115.5
Увс	28 384	15 633	12 751	31 827	17 113	14 714	112.1
Ховд	27 909	15 469	12 440	32 559	17 870	14 689	116.7
ХАНГАЙН БҮС	220 594	119 329	101 265	255 708	136 587	119 121	115.9
Архангай	36 841	19 867	16 974	42 464	22 708	19 756	115.3
Баянхонгор	33 587	17 911	15 676	40 362	21 100	19 262	120.2
Булган	24 414	13 439	10 975	27 182	14 849	12 333	111.3
Орхон	35 897	19 357	16 540	39 301	21 061	18 240	109.5
Өвөрхангай	42 478	23 055	19 423	51 303	27 485	23 818	120.8
Хөвсгөл	47 377	25 700	21 677	55 096	29 384	25 712	116.3
ТӨВИЙН БҮС	193 044	110 983	82 061	208 338	114 972	93 366	107.9
Говьсүмбэр	5 704	3 163	2 541	6 952	3 697	3 255	121.9
Дархан-Уул	34 988	19 108	15 880	39 582	21 415	18 167	113.1
Дорноговь	26 087	14 751	11 336	30 212	16 434	13 778	115.8
Дундговь	17 393	9 328	8 065	21 364	11 402	9 962	122.8
Өмнөговь	33 794	22 061	11 733	31 294	17 489	13 805	92.6
Сэлэнгэ	39 101	21 923	17 178	40 425	22 859	17 566	103.4
Төв	35 977	20 649	15 328	38 509	21 676	16 833	107.0
ЗҮҮН БҮС	75 868	42 306	33 562	92 458	50 694	41 764	121.9
Дорнод	26 098	14 655	11 443	35 508	19 369	16 139	136.1
Сүхбаатар	22 952	12 808	10 144	28 091	15 416	12 675	122.4
Хэнтий	26 818	14 843	11 975	28 859	15 909	12 950	107.6
						286 001	
УЛААНБААТАР	452 255	243 208	209 047	587 159	301 158		129.8



Аймгийн түвшинд ажиллах хүчний тоог 2010 онтой харьцуулахад, Өмнөговь аймагт 2.5 мянга буюу 7.4 хувиар буурсан бол Улаанбаатар хотод 134.9 мянга (29.8%)-аар, бусад аймгуудад 1.3-9.4 мянга буюу 3.4-36.1 хувиар өссөн байна.

Ажиллах хүчний хүйсээрх ялгааг аймаг, нийслэлийн түвшинд авч үзэхэд, нийслэл болон бүх аймагт эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийнхээс их байгаа бөгөөд хамгийн их ялгаатай байгаа нь Сэлэнгэ аймагт 13.1 пунктээр, хамгийн бага нь Улаанбаатар хотод 2.6 пунктээр их байна. Уг хүйсээрх ялгаатай байдал нийслэл, аймгийн түвшинд 2010 онд мөн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс (6.7-30.6 пункт) их байсан ба Өмнөговь аймагт хамгийн их ялгаатай буюу эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эмэгтэйчүүдийнхээс 30.6 пунктээр их байсан бол 2020 онд 11.8 болж буурсан нь хамгийн их өөрчлөлттэй байна.

Ажиллах хүчний оролцооны түвшнийг өмнөх тооллого буюу 2010 онтой харьцуулахад Улаанбаатар хот болон Дорнод, Дархан-Уул, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Архангай, Төв аймагт 0.1-10.7 пунктээр өсөж, бусад аймагт 0.1-15.0 пунктээр буурсан байна.


Хэдийгээр ажиллах хүчний оролцооны түвшин бууралттай аймгууд байгаа хэдий ч Улаанбаатар хот, Өмнөговь аймгаас бусад бүх аймагт хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх тооллогын үеэс 2.7-19.8 пунктээр өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Өмнөговь аймагт сүүлийн 10 жилд уул уурхайн салбарын хөгжил эрчимжсэнтэй шууд холбоотойгоор тус аймгийн хотжилтын түвшин 6.8 пунктээр өсөж, төв, суурин газрын хүн амын тоо өссөн. Гэсэн хэдий ч тус аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 9.0 пунктээр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2.5 пунктээр, ажилгүйдлийн түвшин 8.2 пунктээр тус тус буурсан байна. Энэ нь тухайн аймгийн хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь нэмэгдсэн, иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох идэвх буурч байгаагийн илэрхийлэл бөгөөд энэ хандлагыг цаашид тусгайлан судлах нь зүйтэй.

Ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн их бууралттай байгаа нь Баян-Өлгий (15.0 пункт), Увс (9.6 пункт), Өмнөговь (9.0 пункт), Завхан (8.4 пункт), Ховд (6.2 пункт) аймаг байгаа бол хөдөлмөр эрхлэлтийн түвшин Завхан (19.8 пункт), Говь-Алтай (16.5 пункт), Ховд (13.4 пункт), Увс (13.1 пункт) аймагт хамгийн их өсөлттэй байна.



ЗУРАГ 5.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ 2010 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ПУНКТЭЭР, 2020 ОН




Баянхонгор аймагт ажиллах хүчний оролцооны (67.7%) болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин (63.6%) хамгийн их байгаа бол Баян-Өлгий аймагт хамгийн бага буюу ажиллах хүчний оролцооны түвшин 48.7 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 41.3 хувьтай байна. Улаанбаатар хотод ажиллах хүчний оролцооны түвшин улсын дунджаас 0.4 пунктээр бага буюу 59.3 хувь байна. Аймгуудын хувьд Баян-Өлгий, Сэлэнгэ, Хэнтий, Орхон, Ховд, Дархан-Уул, Увс аймагт улсын дунджаас 1.7-11.0 пунктээр бага, бусад аймагт улсын дунджаас 0.2-8.0 пунктээр их байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшний хувьд, Улаанбаатар хотод болон Баян-Өлгий, Сэлэнгэ, Хэнтий, Орхон, Ховд, Дархан-Уул, Увс аймагт улсын дунджаас 3.1-12.5 пунктээр бага, бусад аймагт улсын дунджаас 2.6-9.8 пунктээр их байна.



ЗУРАГ 5.2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажиллах хүчний оролцоог аймаг, нийслэлээр авч үзэхэд Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар аймагт хамгийн их буюу 13.0-13.5 пунктын зөрүүтэй байгаа бол Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу 8.5 пунктын зөрүүтэй байна.

Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 40-44 насанд хамгийн их буюу 81.7 хувь байгаа бөгөөд ихэнх аймагт энэ насны бүлэгт ажиллах хүчний оролцооны түвшин их байгаа юм. Баянхонгор аймгийн хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин ихэнх насны бүлэгт бусад аймгуудаас их байна. Харин Баян-Өлгий аймагт 15-34 насны бүлэгт, Хэнтий аймагт 35-39 насны бүлэгт, Орхон аймагт 40, түүнээс дээш насны бүлэгт ажиллах хүчний оролцооны түвшин бусад аймагтай харьцуулахад бага байна.

Баянхонгор аймагт насны бүлгээрх ажиллах хүчний оролцооны түвшин их байхад тус аймгийн эмэгтэйчүүдийн оролцоо ихэнх насны бүлэгт бусад аймгаас их байгаа нь нөлөөлсөн байна. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин Баянхонгор аймагт 30-39, 45-49 насны бүлэгт хамгийн их, бусад насны бүлэгт мөн их аймгуудад багтаж байгаа бол 15-24 насны бүлэгт Сүхбаатар аймагт, 25-34 насны бүлэгт Дорнод аймагт, 40-44, 50 болон түүнээс дээш насны бүлэгт Архангай аймагт хамгийн их байна.



ХҮСНЭГТ 5.2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65+
БҮГД	59.7	7.7	44.4	73.1	80.4	80.9	81.7	80.8	74.5	53.4	25.2	10.7
Архангай	65.4	8.8	49.7	81.5	88.3	89.8	90.4	88.6	84.4	64.9	39.2	17.7
Баян-Өлгий	48.7	2.7	26.2	54.2	70.7	76.6	77.1	75.9	72.2	52.7	27.0	9.5
Баянхонгор	67.7	15.9	56.7	82.1	88.0	89.6	89.7	89.3	83.9	62.6	37.4	16.0
Булган	62.9	8.8	45.3	74.6	83.3	84.7	87.0	84.6	81.1	65.3	41.0	20.0
Говь-Алтай	65.3	10.3	49.9	81.5	86.3	88.0	88.2	87.5	84.0	64.7	40.6	19.5
Дорноговь	63.6	10.7	54.1	79.5	83.5	83.4	83.7	81.7	75.4	52.7	30.9	13.7
Дорнод	64.0	9.9	53.8	86.1	88.5	86.3	86.3	83.7	75.9	50.6	17.3	6.0
Дундговь	65.6	11.4	54.2	82.1	86.7	88.7	89.9	88.9	82.7	63.8	42.4	21.3
Завхан	59.9	6.8	43.0	74.6	84.0	84.1	84.2	83.7	77.8	55.6	30.7	13.2
Өвөрхангай	64.5	11.1	51.5	79.6	86.3	87.4	87.8	88.0	81.8	59.2	37.6	19.6
Өмнөговь	65.7	10.2	52.6	79.6	82.9	84.3	84.5	83.5	78.4	63.5	43.9	20.0
Сүхбаатар	65.2	15.9	58.9	83.5	86.9	87.2	86.4	83.5	76.0	50.4	24.7	7.9
Сэлэнгэ	53.9	6.8	41.0	68.7	74.6	74.1	75.0	73.2	67.6	48.3	23.8	9.1
Төв	60.4	8.0	47.8	75.8	80.3	81.3	82.9	82.8	76.6	56.7	34.6	16.0
Увс	58.0	9.4	44.4	74.9	81.6	82.3	81.0	80.4	71.5	50.4	30.6	17.5
Ховд	55.8	6.3	39.9	71.3	79.5	80.1	79.9	81.1	72.8	53.1	27.8	10.4
Хөвсгөл	60.0	8.6	43.5	72.2	82.4	82.0	83.4	82.3	76.3	56.0	31.6	14.4
Хэнтий	54.3	8.3	40.8	67.6	73.7	74.0	75.1	75.0	67.3	51.4	34.2	13.7
Дархан-Уул	56.4	6.2	41.8	72.2	78.9	78.8	78.8	78.5	69.2	46.0	18.8	4.8
Орхон	54.6	6.7	47.0	71.7	75.5	76.3	74.8	73.2	64.4	34.6	13.3	3.3
Говьсүмбэр	60.8	7.0	51.2	77.2	82.2	81.4	84.2	80.7	73.3	46.1	24.9	6.0
Улаанбаатар	59.3	6.0	41.4	71.2	79.3	79.3	80.4	79.5	73.5	52.6	19.3	7.6

Аймгийн түвшинд байршлаар авч үзэхэд, Архангай, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Сүхбаатар, Булган аймагт хөдөөд хот, суурин газраас 0.1-6.4 пунктээр их байгаа бол бусад аймагт 0.5-49.1 пунктээр бага байна (Орхон 49.1 пунктээр, Дархан-Уул 36.0 пунктээр, Дорнод 24.1 пунктээр).



ХҮСНЭГТ 5.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	59.7	65.3	54.6	58.2	63.3	53.6	33.7	40.4	27.9
Архангай	65.4	70.3	60.6	54.4	56.8	52.2	60.7	66.3	55.3
Баян-Өлгий	48.7	53.9	43.7	47.8	50.8	45.1	37.2	43.2	31.6
Баянхонгор	67.7	73.2	62.5	58.9	64.0	54.7	59.2	65.8	53.0
Булган	62.9	68.0	57.7	56.5	60.4	52.8	56.6	62.4	50.7
Говь-Алтай	65.3	69.9	60.8	57.8	60.7	55.1	57.2	62.8	51.9
Дорноговь	63.6	69.9	57.5	60.4	66.3	55.0	41.5	49.8	34.1
Дорнод	64.0	69.6	58.3	66.9	71.1	63.2	42.8	52.0	33.5
Дундговь	65.6	70.5	60.8	56.9	59.4	54.9	59.7	65.8	53.7
Завхан	59.9	65.9	54.1	56.1	59.5	53.1	54.1	60.9	47.6
Өвөрхангай	64.5	70.3	58.9	57.5	63.4	52.4	57.7	64.4	51.4
Өмнөговь	65.7	72.4	58.9	56.1	60.8	52.1	56.9	65.3	48.1
Сүхбаатар	65.2	71.7	58.7	58.1	62.7	54.0	58.3	66.0	50.7
Сэлэнгэ	53.9	60.2	47.5	52.9	58.6	47.4	43.6	50.4	36.9
Төв	60.4	66.2	54.3	56.4	61.2	52.1	56.0	62.4	49.2
Увс	58.0	62.9	53.2	50.4	55.0	46.2	48.3	53.6	43.2
Ховд	55.8	62.1	49.7	54.3	58.5	50.4	45.4	52.7	38.4
Хөвсгөл	60.0	65.6	54.7	55.0	59.5	51.0	51.2	57.5	45.2
Хэнтий	54.3	59.5	49.1	46.2	48.9	43.7	45.5	51.6	39.3
Дархан-Уул	56.4	63.4	49.9	56.8	63.5	50.7	20.8	27.4	15.5
Орхон	54.6	60.6	49.0	54.3	60.2	48.7	5.2	7.1	3.7
Говьсүмбэр	60.8	65.0	56.5	59.0	62.1	56.1	39.3	44.9	33.9
Улаанбаатар	59.3	64.6	54.7	59.3	64.6	54.7	-	-	-

Аймаг, нийслэлийн хувьд дээд боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр, суурь боловсролтой болон боловсролгүй хүн амынх хамгийн доогуур байна. Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт боловсролгүй болон бага боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн бага байна.



ХҮСНЭГТ 5.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
БҮГД	76.7	56.4	66.6	54.4	45.5	52.7	41.7
Архангай	80.1	60.1	75.3	58.5	62.8	69.0	50.9
Баян-Өлгий	66.1	56.0	59.2	44.2	33.8	51.9	40.4
Баянхонгор	83.1	64.1	72.9	62.8	67.6	59.2	50.2
Булган	76.9	59.8	69.8	61.2	58.7	55.7	47.0
Говь-Алтай	81.3	66.7	75.1	58.6	60.8	60.8	53.5
Дорноговь	81.4	64.9	75.1	58.7	51.6	53.4	45.4
Дорнод	84.8	62.6	73.4	63.1	50.9	49.6	46.3
Дундговь	80.7	63.9	74.4	56.4	63.6	65.4	49.2
Завхан	79.1	59.3	69.3	53.3	52.1	57.5	52.6
Өвөрхангай	81.1	61.7	72.9	57.1	60.7	65.4	58.3
Өмнөговь	78.3	64.0	78.1	60.5	57.9	59.7	49.0
Сүхбаатар	84.0	56.0	70.9	58.4	61.3	64.7	58.9
Сэлэнгэ	77.7	55.5	63.2	51.5	39.8	35.9	29.2
Төв	77.0	57.6	68.5	58.0	54.7	51.5	40.1
Увс	77.9	55.4	66.3	47.9	48.2	66.0	50.8
Ховд	74.6	56.5	62.8	51.2	46.8	48.2	46.9
Хөвсгөл	79.0	60.7	68.8	55.8	53.2	60.4	50.5
Хэнтий	78.0	53.9	66.7	50.0	46.9	46.2	39.5
Дархан-Уул	76.3	52.7	62.8	52.7	31.4	26.5	27.6
Орхон	75.5	48.0	59.9	50.4	25.7	22.2	23.8
Говьсүмбэр	82.0	64.7	74.4	55.3	43.3	40.5	36.6
Улаанбаатар	75.8	54.7	62.6	53.7	24.9	21.8	21.6

АЖИЛЛАГЧДЫН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Хөвсгөл, Өвөрхангай, Өмнөговь, Төв аймагт ажиллагчдын тоо 2010 оноос 1.1-29.0 хувиар буурч, Завхан, Ховд аймаг 1.3 дахин, бусад аймаг болон Улаанбаатар хотод 0.2-94.7 хувиар өссөн байна.

Аймгийн түвшинд ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны дэд салбараар авч үзэхэд, Архангай, Дундговь, Баянхонгор, Сүхбаатар, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Говь-Алтай, Увс аймагт хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид зонхилж, аж




үйлдвэрийн салбарт ажиллагчид багахан хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл 50.0-59.9 хувь нь хөдөө аж ахуйн, 30.6-39.7 хувь нь үйлчилгээний, 7.8-12.1 хувь нь аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна.

Завхан, Төв, Баян-Өлгий, Хэнтий, Ховд аймагт хөдөө аж ахуйн болон үйлчилгээний салбарт ажиллагчид зонхилж байгаа бөгөөд уг 2 салбарт ажиллагчдын эзлэх хувь ойролцоо байна. Өөрөөр хэлбэл, 40.4-46.9 хувь нь хөдөө аж ахуйн, 39.0-47.3 хувь нь үйлчилгээний, 7.8-15.9 хувь нь аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна.

Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ аймагт ажиллагчдын ихэнх нь үйлчилгээний салбарт ажиллаж, хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын эзлэх хувийн жин ойролцоо байна. Тухайлбал, 46.7-51.6 хувь нь үйлчилгээний, 27.5-29.8 хувь нь хөдөө аж ахуйн, 20.6-23.5 хувь нь аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна.

Дорноговь, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймаг болон Улаанбаатар хотод үйлчилгээний салбарт ажиллагчид 53.4-72.0 хувийг эзэлж байгаа бол аж үйлдвэрийнх 14.7-42.1 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 2.1-24.6 хувийг эзэлж байна.


ЗУРАГ 5.3. АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭД САЛБАР, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Булган аймагт цалин хөлстэй ажилтан ажиллуулдаггүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид (45.2-57.1 хувь) зонхилж, энэ хадлагыг дагаад гэр бүлийн гишүүдэд хувь нэмэр оруулагчид бусад аймагтай харьцуулахад их хувийг эзэлж байгаа дүр зураг ажиглагдаж байна. Бусад аймагт цалин хөлстэй ажиллагчид (47.5-87.7 хувь)-ын эзлэх хувийн жин их байна.



ЗУРАГ 5.4. АЖИЛЛАГЧИД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Баруун бүс нутаг харьцангуй олон хүн амтай, суурьшлын хувьд нягт хэдий ч хотжих явц эрчимтэй биш байна. Төвийн бүс Улаанбаатар хотын дараа хотжилт хамгийн өндөр бүс хэвээр байна. Тухайлбал, Орхон, Дархан-Уул аймагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимжсэн, төмөр зам гэх мэт дэд бүтэц сайтай, Өмнөговь аймагт сүүлийн 10 жилд уул уурхайн салбарын хөгжил эрчимжсэнтэй шууд холбоотойгоор тус аймгуудын төв, суурин газрын хүн амын тоо өсөх хандлагатай байна. Харин Дорноговь аймгийн төв, суурин газрын хүн амын өсөлт аж үйлдвэрийн цогцолбор байгуулагдаж байгаатай холбоотой байж болох юм.

АЖИЛГҮЙДЛИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


Ажилгүй иргэдийн тоог аймгийн түвшинд 2010 онтой харьцуулахад, Улаанбаатар хотод 40.3 хувь, Дорнод аймагт 29.4 хувиар өсөж, бусад аймагт 24.2-80.5 хувиар буурсан байна.

Харин ажилгүйдлийн түвшин Улаанбаатар хотод 1.1 пункт, Баян-Өлгий аймагт 0.1 пунктээр өсөж, бусад аймагт 1.1-16.1 пунктээр буурсан байна. Хамгийн их бууралттай байгаа нь Өвөрхангай аймаг (16.1 пункт), хамгийн бага бууралттай Дорнод аймаг (1.1 пункт) байна.



Дорнод, Баян-Өлгий аймаг болон Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 4.6-10.9 пунктээр их байгаа бол бусад аймагт 2.1-7.3 пунктээр бага байна. Ажилгүйдлийн түвшин Төв (2.6%), Өвөрхангай (3.1%), Дорноговь (3.5%) аймагт хамгийн бага, Дорнод (20.8%), Баян-Өлгий (15.2%) аймаг болон Улаанбаатар (14.5%) хотод хамгийн өндөр байна.

ЗУРАГ 5.1. АЖИЛГҮЙ ИРГЭД, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН





ЗУРГААДУГААР БҮЛЭГ

**ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА
МОНГОЛ УЛСЫН ИРГЭД**



Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэдийг тооллогын үед хөдөлмөр эрхлэх зорилгоор гадаадад оршин сууж байгаа иргэдээр тооцсон болно. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 122.3 мянган иргэн тоологдож 2010 оноос 14.2 хувиар өсжээ. Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцийг харвал 0-14 насны хүн ам 12.7 хувь, 15-44 насныхан 72.3 хувь, 45-64 насныхан 14.4 хувь, 65 ба түүнээс дээш насныхан 0.6 хувийг эзэлж байна. Гадаадад удаан хугацаагаар оршин суугаа хүн амын 106.8 мянга (87.3%) нь хөдөлмөрийн насны хүн ам, тэдгээрийн 46.3 хувь нь эрэгтэйчүүд, 53.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 6.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020			2020 2010
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	95 836	44 280	51 556	106 765	48 655	58 110	111.4
15-19	9 176	4 420	4 756	7 262	3 782	3 480	79.1
20-24	20 400	10 164	10 236	16 060	8 484	7 576	78.7
25-29	20 739	10 161	10 578	19 954	10 155	9 799	96.2
30-34	16 855	7 500	9 355	19 820	9 507	10 313	117.6
35-39	13 343	5 797	7 546	14 176	6 102	8 074	106.2
40-44	7 930	3 380	4 550	11 083	4 221	6 862	139.8
45-49	4 168	1 628	2 540	8 798	3 112	5 686	2.1*
50-54	1 883	742	1 141	5 140	1 769	3 371	2.7*
55-59	709	269	440	2 647	902	1 745	3.7*
60-64	304	117	187	1 080	365	715	3.6*
65-69	162	54	108	396	149	247	2.4*
70+	167	48	119	349	107	242	2.1*

Тайлбар: * - Дахин их

Гадаадад оршин суугаа Монгол Улсын 15, түүнээс дээш насны иргэдийн 39.2 мянга (36.7%) нь хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд 64.3 хувь нь хувиараа, 32.6 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, 3.1 хувь нь албан томилолтоор ажиллаж байна.

ХҮСНЭГТ 6.2. ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭЛБЭР, ХҮЙСЭЭР, 2020 ОН

	Бүгд	Хөдөлмөрийн гэрээгээр	Албан томилолтоор	Хувиараа
БҮГД	39160	12774	1199	25187
Эрэгтэй	19560	7314	737	11509
Эмэгтэй	19600	5460	462	13678
Дүнд эзлэх хувь				
БҮГД	100.0	100.0	100.0	100.0
Эрэгтэй	49.9	57.3	61.5	45.7
Эмэгтэй	50.1	42.7	38.5	54.3



Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа манай улсын иргэдийн 82.9 хувь нь 25-49 насныхан байгаа нь хүйсийн хувьд мөн адил байна. Тухайлбал, 30-34 насныхан 21.5 хувь, 35-39 насныхан 17.1 хувь, 25-29 насныхан 16.7 хувь байна.


ХҮСНЭГТ 6.3. ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	39160	19560	19600	100.0	100.0	100.0
15-19	391	235	156	1.0	1.2	0.8
20-24	2663	1778	885	6.8	9.1	4.5
25-29	6556	3997	2559	16.7	20.4	13.1
30-34	8428	4661	3767	21.5	23.8	19.2
35-39	6698	3297	3401	17.1	16.9	17.4
40-44	6022	2527	3495	15.4	12.9	17.8
45-49	4767	1785	2982	12.2	9.1	15.2
50-54	2289	804	1485	5.8	4.1	7.6
55-59	960	342	618	2.5	1.8	3.1
60-64	289	101	188	0.7	0.5	1.0
65-69	62	24	38	0.2	0.1	0.2
70+	35	9	26	0.1	0.1	0.1

Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа манай улсын иргэдийн 41.4 хувь нь 2-5 жилийн, 27.4 хувь нь 1 жил хүртэл, 16.0 хувь нь 6-10 жилийн, 15.2 хувь нь 11 болон түүнээс дээш хугацаатай гадаадад зорчсон байна.

Хүйсийн хувьд авч үзэхэд, 1 жил хүртэл хугацаагаар зорчсон эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 14.9 пунктээр их байгаа бол 6-10 жил (11.6 пунктээр их), 11 ба түүнээс дээш жилээр (15.4 пунктээр их) зорчигсдод эмэгтэйчүүд их хувийг эзэлж байна. Харин 2-5 жилийн хугацаатай зорчигсдод хүйсийн ялгаа байхгүй байна.


ЗУРАГ 6.1. ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ЗОРЧСОН ХУГАЦАА, ХҮЙСЭЭР, 2020 ОН





Хөдөлмөрийн гэрээгээр болон хувиараа ажиллаж байгаа 5 хүн тус бүрийн 2 нь 2-5 жилийн хугацаатай зорчсон бол албан томилолтоор ажиллаж байгаа бараг 2 хүн тутмын 1 нь 1 жил хүртэл хугацаагаар зорчсон байна.

ЗУРАГ 6.2 ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭЛБЭР, ЗОРЧСОН ХУГАЦАА, ХҮЙСЭЭР, 2020 ОН





ՏԱՎՈՐԱԿ



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
ТООЛЛОГО		
1	Хүн ам, орон сууцны тооллого	Товлон тогтоосон хугацаанд тухайн улс оронд (буюу түүний нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг) оршин суугаа нийт хүн амыг хамарч, тэдний амьдарч буй сууцны талаарх суурь мэдээллийг цуглуулах, боловсруулах, хүн ам зүйн, эдийн засаг, нийгмийн дүн шинжилгээ хийх, үнэлэх, хэвлэн нийтлэх, нийтэд тархаах цогц үйл ажиллагаа.
2	Тооллогын тов	Тооллого явуулах хугацааны эхний өдөрт шилжих шөнийн 00 цагийг; 2020 оны 1 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн “00” /тэг тэг/ цагийг ойлгоно.
3	Тоолох үе	2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 08 цагаас 1 дүгээр сарын 15-ны өдрийн 22 цаг хүртэлх хугацаа.
4	Тооллогын нэгж	Хувь хүн, түүний амьдарч байгаа байр, орон сууц.
ХҮН АМ		
5	Оршин суугаа хүн ам	Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийг хэлнэ.
6	Бэлэн хүн ам	Тооллого явуулж буй үед тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа нийт хүн амыг (байнга болон түр хугацаагаар амьдарч байгаагаас үл хамаарч) хэлнэ.
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ		
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг ойлгоно.
8	Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
9	Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
10	Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.



№	Ойлголт	Тодорхойлолт
11	Ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
12	Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
13	Хөдөлгөөний	Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
14	Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.
15	Хавсарсан	Хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд тооцно.
16	Бусад	Дээрхээс бусад ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан буюу хязгаарлагдсан.
СУУРЬШИЛ		
27	Байнга оршин суугаа	Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн
28	Түр эзгүй байгаа	Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааны нэгжээс гадагш 6 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн
29	Түр оршин суугаа	Өөр засаг захиргааны нэгжээс ирж, тооллогын товын өмнө тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн
БОЛОВСРОЛ		
30	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол <i>Боловсролгүй</i> хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг <i>Боловсролгүй</i> гэж үзнэ.
31	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн



№	Ойлголт	Тодорхойлолт
32	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
33	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг 2005 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006-2014 онуудад, 12 дугаар ангийг 2015 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн
34	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
35	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
36	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.
37	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
38	Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэнэ.



№	Ойлголт	Тодорхойлолт
ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ		
39	Огт гэрлээгүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
40	Гэрлэсэн батлуулаагүй	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
41	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
42	Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Тусгаарласан гэж үзнэ. Гэхдээ албан ажлын улмаас 2 тусдаа амьдарч байгаа хүнийг тусгаарласан гэж үзэхгүй.
43	Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Цуцалсан гэж үзнэ.
44	Бэлэвсэн	Эхнэр/нөхрийн аль нэг нь нас барснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Бэлэвсэн гэж үзнэ.
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ		
45	Ажил эрхэлдэг хүн	Сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн болон ер нь цалинтай ажил/бизнесийн үйл ажиллагаа байгаа хүн ам.
46	Ажилгүй хүн	Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.
47	Боломжит ажиллах хүч	Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд: а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн; б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.
48	Хөдөлмөрийн насны хүн ам	15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.



№	Ойлголт	Тодорхойлолт
49	Ажиллах хүч	Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.
50	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно.
51	Цалин хөлстэй байнгын ажиллагч	Ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч о.
52	Цалин хөлстэй түр ажиллагч	Хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3, түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.
53	Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	Ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм
54	Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан	Цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй ажиллагч юм.
55	Гүйцэтгэх гэрээлэгч	Эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.



№	Ойлголт	Тодорхойлолт
56	Аж ахуйн нэгж, байгууллагын олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.
57	Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуй нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуй нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.
58	Ажилтан ажиллуулдаггүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилчид юм.
59	Ажилтан ажиллуулдаггүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажиллагч авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилчид юм.
60	Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	Өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.



№	Ойлголт	Тодорхойлолт
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ		
61	Менежер	Менежер нь Засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг хамруулна. Тухайлбал, төрийн болон хувийн аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын бүх төвшний дарга, захирал, хууль тогтоогч, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, бүх төвшний засаг дарга, захирагч, ТББ-ын удирдах албан тушаалтан, менежер гэх мэт.
62	Мэргэжилтэн	Мэргэжилтэн нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, тэдгээрийг системтэйгээр заах сургах буюу мэргэжлийн өндөр төвшин шаардсан ажил гүйцэтгэгч байна. Тухайлбал, шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн, эмч, сувилагч, багш, судлаач, бизнесийн болон захиргааны мэргэжилтэн, программ зохиогч, шашны мэргэжилтэн, уран бүтээлч, дуучин, жүжигчин гэх мэт.
63	Техникч туслах/дэд мэргэжилтэн	болон Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн нь шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ. Тэд уул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн арга ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулна. Физик, инженерийн ухааны техникч, уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч, технологи процесс, чанар шалгагч, амьд ертөнц судлах ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн, усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч гэх мэт.
64	Контор, үйлчилгээний ажилтан	Тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах ба мөнгөний гүйлгээ хийх, аялал жуулчлал зохион байгуулах, мэдээлэл авах, хүсэлт тавих, уулзалт товлох зэрэг туслах шинжтэй олон төрлийн үүргийг гүйцэтгэнэ. Компьютерын операторч, үйлчилгээний туслах ажилтан, тооцоолол, материал, тоо бүртгэлийн ажилтан, конторын бусад туслах ажилтан гэх мэт.



№	Ойлголт	Тодорхойлолт
65	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах юм уу хууль бус үйлдэл, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мухлагаар бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Хувийн үйлчилгээний ажилтан, худалдааны ажилтан, хувь хүн асрах ажилтан, хамгаалах үйлчилгээний ажилтан гэх мэт.
66	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж, үржүүлнэ. Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан, өрхийн хэрэгцээний шинжтэй фермерч, загасчин, анчин болон түүн цуглуулагч гэх мэт.
67	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металлд хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх салбарт мэдлэг, ур чадвараа хэрэглэнэ. Металл, машин, механизм, түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан, гар урлал, хэвлэлийн ажилтан, цахилгаан болон цахим техникч, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч гэх мэт.
68	Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	Хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийг биечлэн жолоодох эсвэл алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах, галт тэрэг, хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, зааварлах, угсрах ажил эрхэлнэ. Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч гэх мэт.



№	Ойлголт	Тодорхойлолт
69	Энгийн мэргэжил	ажил, Энгийн ажил эрхлэгч нь өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ. Цэвэрлэгч, туслагч, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил, хүнс бэлтгэлийн туслах ажил, гудамж дахь худалдаа, үйлчилгээний ажил, бусад энгийн ажил гэх мэт.
70	Зэвсэгт хүчний мэргэжил	ажил, Зэвсэгт хүчний офицерын цол бүхий Монгол Улсын Зэвсэгт хүчний зохих албан тушаалд цэргийн алба хаахыг офицерын алба гэнэ. Зэвсэгт хүчний офицер нь төрөл бүрийн энгийн ажил, мэргэжилд байдаг ижил төстэй үүрэг гүйцэтгэж болно. Энэ бүлэгт Зэвсэгт хүчинд алба хааж байгаа дунд офицер, ахлах офицер, дээд офицерын нийт бие бүрэлдэхүүн багтана.

ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛАЛ

71	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Тухайн салбарт мал, амьтны болон ургамлын байгалийн нөөц ашиглалт хамаарна. Энэ салбарт хөдөө аж ахуйн ургамал ургуулах, мал, амьтан, үүний дотор үржлийн мал, амьтныг өсгөн үржүүлэх үйл ажиллагаа, мод бэлтгэл, фермд ч, байгаль орчинд ч бусад ургамал, мал, амьтан буюу мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний бэлтгэл орно.
72	Уул уурхай, олборлолт	Байгалийн хатуу, шингэн эсвэл хий (байгалийн хий) зэрэг эрдэс баялгийг олборлох уул уурхайн үйл ажиллагаа багтана. Олборлох үйл ажиллагаа нь далд эсвэл ил уурхай, далайн ёроолын уурхай гэх мэт уурхайгаас төрөл бүрийн аргаар гаргаж авах үйл ажиллагаа байж болно.
